Golomt Capital®
*Delivering diversity*

# BLUEBOOK-VI

GRAND BULL
AWARDS
2019-2023

ШИЛДЭГ ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИ

ШИЛДЭГ БРОКЕРИЙН КОМПАНИ

ОНЦЛОХ ЗАХИРАЛ

ОНЦЛОХ IPO

БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ШИЛДЭГ ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ

ОНЦЛОХ ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН





# АГУУЛГА


**ДЭЛХИЙД ЮУ БОЛОВ?** **8**

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ 2024 ОН** **13**

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ 21

ДОТООДЫН ХУВЬЦААНЫ ТАНИЛЦУУЛГА 27

**ГОЛОМТ КАПИТАЛЫН САНАЛ БОЛГОЖ БУЙ БОНДУУД** **35**

ЗАСГИЙН ГАЗРЫН АМ.ДОЛЛАРЫН БОНД 40

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ 2023 ОНД 43

АНУ-ЫН ХУВЬЦААНЫ ЗАХ ЗЭЭЛ 2023 ОН 46

БНХАУ-ЫН ХУВЬЦААНЫ ЗАХ ЗЭЭЛ 2023 ОН 49

**ДЭЛХИЙН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ 2024 ОН** **52**

АНУ-ЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ 2024 ОН 55

БНХАУ-ЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ 2024 ОН 64

ОНЦЛОХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ 70

ГАДААДЫН ХУВЬЦААНЫ ТАНИЛЦУУЛГА 74

**БИД ТАНД ЮУ ӨГЧ ЧАДАХ ВЭ?** **86**



# МЭНДЧИЛГЭЭ

**| Танд энэ өдрийн мэнд хүргэе!**

Эрхэм тантай 2024 оны дэлхийн болон монголын эдийн засаг, хөрөнгийн зах зээлийн чиг хандлага, хөрөнгө оруулах боломжтой бүтээгдэхүүн, үйлчилгээг танилцуулахаар зорин бэлтгэсэн "BLUEBOOK-6" товхимлоороо уулзаж буйдаа таатай байна.

2023 он Голомт Капитал ҮЦК-ийн хувьд бизнесийн голлох үзүүлэлтүүд өссөн, хүний нөөц, харилцагчийн үйлчилгээ, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, компанийн брэндинг, бизнес процесс болон IT хөгжүүлэлт, хөрөнгийн зах зээлийн мэдлэг олгох, нийгмийн хариуцлагын хүрээнд олон ажлыг санаачлан хэрэгжүүлсэн жил байлаа.

Бид 2023 онд Монголын бондын зах зээлийн 46 хувийг дангаар гүйцэтгэж, нээлттэй болон хаалттай зах зээлд үйлдвэрлэл худалдаа, банк санхүү, барилга, уул уурхай, дэд бүтэц, технологи зэрэг 7 салбарын 30 гаруй компанийн нийт 300 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг амжилттай татан төвлөрүүлээд байна.

Тэр дундаа Монголын анхны BBB+ үнэлгээтэй бонд, анхны "A" зээлжих зэрэглэлтэй компанийн бондыг харилцагчдадаа санал болгож, Монголын хөрөнгийн зах зээлийн түүхэнд цоо шинэ хуудсыг нээлээ.

Мөн бид үйл ажиллагааныхаа цар хүрээг өргөтгөж Уул уурхайн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн тусгай зөвшөөрлийг Монголд анх удаа авснаас гадна гадаад арилжааны зах зээлд ч тэргүүлэх байр суурьтай ажиллаж, нийт 1 тэрбум ам.долларын гадаад арилжааг гүйцэтгэсэн амжилтыг 80 мянга гаруй идэвхтэй харилцагчдынхаа хамтаар үзүүллээ.

Голомт Капитал компанийн энэ бүх амжилтыг 5 жил тутамд хөрөнгийн зах зээлийн шилдгийн шилдгийг шалгаруулдаг Grand Bull Awardsaas өндрөөр үнэлсэн юм.

## БИД 2019-2023 ОНЫ

- Шилдэг үнэт цаасны компани
- Шилдэг брокерийн компани
- Онцлох захирал

номинацид ялалт байгуулсан бол бидэнтэй хамтран ажилласан компаниуд, бидний хөрөнгө оруулагчдад санал болгосон бүтээгдэхүүнүүд ч шилдэг байсныг баталж

- Онцлох Ipo
- Биржийн бус зах зээлийн шилдэг үнэт цаас гаргагч
- Онцлох шинэ бүтээгдэхүүнээр шалгараад байна

Мөн Lemon Press-ээс 3 дахь жилдээ зохион байгуулсан **"Lemon Press awards"**-т саналаа ирүүлсэн 1500 орчим уншигч Голомт Капитал үнэт цаасны компанийг **"Онцлох үнэт цаасны компани"**-иар тодрууллаа.

Бид 2024 онд Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжил, хөрөнгө оруулагч гэр бүлийн төлөө, харилцагчдынхаа хэрэгцээ шаардлагад нийцсэн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг тогтмол нэвтрүүлэн, хөрөнгө оруулалтын луужин байх үүргээ нэрт тэртэйгээр биелүүлэн ажиллахаа илэрхийлж байна.

Та бүхний хөрөнгө оруулалтын шийдвэр мэргэн байг!

Хүндэтгэсэн:

**С.ГАН-ЭРДЭНЭ**
Гүйцэтгэх захирал

# БИДНИЙ ТУХАЙ

Голомт Капитал ҮЦК ХХК нь 2011 онд Голомт банкны 100 хувийн хөрөнгө оруулалттайгаар үүсгэн байгуулагдсан бөгөөд андеррайтер, брокер, хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээг гадаад дотоодын харилцагч, түнш, хамтран ажиллагч харилцагч байгууллагуудаа хүргэж ирсэн.

Голомт Капитал ҮЦК ХХК нь Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжилд хурд нэмсэн анхдагч олон алхмуудыг хийж ирсэн бөгөөд Монголын анхны онлайн арилжааны систем, дэлхийд алдартай Interactive Brokers зэрэг үйлчилгээг нэвтрүүлснээр харилцагч тив дэлхийн хаана ч байсан хүссэн цагтаа (24/7) гадаад, дотоодын хөрөнгийн биржүүдийн арилжаанд оролцож, хувьцаа, бонд, үнэт метал зэрэг бүтээгдэхүүнээс сонголтоо хийх боломжтой болсон юм.

Мөн бид ухаалаг хөрөнө оруулагчдыг бэлтгэх зорилгоор GCC академийг үүсгэн байгуулсан бөгөөд хөрөнгийн зах зээлийн талаарх шат шатны сургалтыг тогтмол зохион байгуулахаас гадна дэлхийн эдийн засаг, хөрөнгийн зах зээл, онцлох компани, хувьцааны талаарх өдөр тутмын мэдээ мэдээлэл болон долоо хоног, улирал, жилийн тайлан судалгааг хүргэн ажиллаж байна.

Бид хувийн болон төрийн эзэмшлийн компани, аж ахуйн нэгжүүдэд хөрөнгө оруулалт татах, санхүүжилт босгох, хэлэлцээр хийх зэрэг хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээг мэргэжлийн түвшинд гүйцэтгэн, хөрөнгийн зах зээлд гарахад нь зуучлан ажиллаж байгаа бөгөөд дараах салбаруудад тэргүүлэгч байр суурьтай байна.

**Үүнд:**

- Брокерийн үйлчилгээ
- Дилерийн үйлчилгээ
- Андеррайтерийн үйлчилгээ
- Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ
- Гадаадын үнэт цаасны зах зээл дээр үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа
- Мөнгөн хөрөнгийн номинал дансны үйлчилгээ
- Уул уурхайн биржийн арилжааны зуучлагч /брокер/ эрхлэх тусгай зөвшөөрлүүдийг Санхүүгийн Зохицуулах Хорооноос авч 2011 оноос хойш тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна.

Бид харилцагчдынхаа эрх ашгийг ямагт дээдлэн Монголын үнэт цаасны зах зээлийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулан, зах зээлд тэргүүлэгч хөрөнгө оруулалт, брокерийн компани болохын төлөө идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

# ДЭЛХИЙД
# ЮУ
# БОЛОВ?



# ДЭЛХИЙД ЮУ БОЛОВ?

## ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ



**Т.Азтүшиг**
*Ахлах шинжээч, Хөрөнгө удирдлага, судалгааны газар*

Ирэх оны дэлхийн эдийн засгийг энэ оноос 0.1 хувиар бага буюу 2.9 хувийн өсөлттэй байхаар төсөөлсөн байна.

Үүнд, хөгжингүй орнуудын эдийн засгийг 1.4 хувиар, хөгжиж буй эдийн засагтай орнуудын эдийн засгийг 4 хувиар өснө гэсэн хүлээлттэй байна.

**ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН САНГААС 10 САРД ТАНИЛЦУУЛСАН ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТАЙЛАНД ДУРДСАНААР ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ 2023 ОНД 3.5 ХУВИАР ӨСӨХ ХҮЛЭЭЛТТЭЙ БАЙНА.**

**ҮҮНД, ХӨГЖИНГҮЙ ОРНУУДЫН ЭДИЙН ЗАСАГ 1.5 ХУВИАР, ХӨГЖИЖ БУЙ УЛС ОРНУУДЫН ЭДИЙН ЗАСАГ 4 ХУВИАР ТУС ТУС ӨСӨХ ХҮЛЭЭЛТТЭЙ БАЙГАА ЮМ. ХАРИН ХӨГЖИЖ БУЙ УЛС ОРНУУДААС ЭНЭТХЭГ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ 6.3, БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСАГ 5 ХУВИАР ТУС ТУС ӨСӨХ ХҮЛЭЭЛТТЭЙ БАЙНА.**

**ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН САНГИЙН ТААМАГЛАЛААР 2023 ОНД ХӨГЖИЖ БУЙ АЗИ БҮС НУТАГ ХАМГИЙН ӨНДӨР ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТТЭЙ БАЙХ БА ЭНЭХҮҮ ӨСӨЛТИЙГ ГОЛЧЛОН ХЯТАД УЛС БИЙ БОЛГОНО.**




*Эх сурвалж: IMF World Economic Outlook 2023-10*

## ГЛОБАЛ ДНБ ӨСӨЛТ

*Эх сурвалж: IMF World Economic Outlook*




## ИНФЛЯЦЫН ТҮВШИН ИРЭХ ОНУУДАД БУУРАХ ХҮЛЭЭЛТТЭЙ БАЙНА

Цар тахлын дараах сэргэлтээр буюу 2022 онд дэлхийн инфляц 8.7 хувь буюу 2000 оноос хойших түүхэн дээд түвшиндээ хүрсэн.

Энэхүү эдийн засагт үүссэн хэт халалтыг зогсоох зорилгоор төв банкнууд мөнгөний хатуу бодлогыг хэрэгжүүлсэн юм.

Мөнгөний бодлогоор дамжуулан зах зээл дээрх бэлэн мөнгөний хэмжээг татсанаар инфляцын түвшин оройн цэгүүдээсээ буурч эхэллээ.

2023 онд дэлхийн инфляцын түвшин өнгөрсөн жилээс 1.8 хувиар бага буюу 6.9 хувь, ирэх онд 5.8 хувийн өсөлттэй гарахаар байна.

## ГЛОБАЛ ИНФЛЯЦЫН ТҮВШИН (%)

*Эх сурвалж: IMF World Economic Outlook*



## ИРЭХ ОНД ДИЙЛЭНХ УЛСЫН БОДЛОГЫН ХҮҮ ӨСӨХГҮЙ

Ам.долларын сагсны хүү **дунджаар 5.8 дахин** өссөн

Бодлогын хүүг өсгөхгүй байх **магадлал 95 хувь**

АНУ -ын бодлогын хүү **ирэх оны эхний хагаст буурна**

БНХАУ бодлогын **хүүгээ үргэлжлүүлэн бууруулна**




*Эх сурвалж: Thomson Reuters Eikon*

Ам.долларын индексийн сагсанд багтах улс орнуудын бодлогын хүү 2020 оны 1 сараас 2023 оны 11 сар хүртэл дунджаар 5.8 дахин өссөн байна.

Thomson Reuters Eikon платформ дээрх шинжээчдийн дундаж хүлээлтээр цаашид бодлогын хүү өсөхгүй байх магадлал 95 хувьд хүрээд байгаа бол дийлэнх шинжээчид АНУ-ын төв банкны бодлогын хүүг ирэх оны 3 сард буурна гэсэн хүлээлттэй байна.

## АМ.ДОЛЛАР 2023 ОНД ХҮЧТЭЙ ЧАНГАРЛАА




*Тэмдэглэл: Хаалтын ханш 2023 оны 12 сарын 1-ний өдрөөр*

*Эх сурвалж: Thomson Reuters Eikon*

2023 онд ам.долларын суурь хүү өндөр байснаас шалтгаалж ам.доллар бусад валютын хослолуудын эсрэг хүчтэй чангарлаа.

Цар тахал дэгдэхээс өмнө буюу 2019 оны 12 сарын 31 өдрөөс хойш ам.долларын индекс 9.09 хувиар өссөн бол Японы иений ханшийн эсрэг 38.62 хувиар чангарчээ.

## АМ.ДОЛЛАР 2024 ОНД СУЛРАХ ХҮЛЭЭЛТТЭЙ БАЙНА

| ХОСЛОЛ | ХҮЛЭЭЛТ /1 ЖИЛ |
|---|---|
| USD/JPY | -10.11% |
| USD/CAD | -5.12% |
| USD/SEK | -4.69% |
| USD/GBP | -2.50% |
| USD/EUR | -2.46% |
| USD/CHF | 0.18% |
| Dollar index | -3.75% |

*Эх сурвалж: Thomson Reuters Eikon*

- •АНУ-ЫН БОДЛОГЫН ХҮҮ ХАМГИЙН ХУРДАЦТАЙ ӨССӨН
- •2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД БОДЛОГЫН ХҮҮ БУУРНА
- •ИНФЛЯЦЫН ТҮВШИН ХУРДАЦТАЙ БУУРЧ БАЙГАА

ANZ Bank, Barclays, BofA, Citigroup, Commerzbank, Deutsche Bank, JP Morgan, Nomura, Standard Chartered, Wells Fargo, Credit Suisse, Goldman Sachs, Morgan Stanley, Scotiabank зэрэг хөрөнгө оруулалтын 77 банк оролцсон валютын ханшийн таамаглалаар ирэх онд ам.долларын индекс 3.75 хувиар буурах хүлээлттэй байна.

Ам.долларын индексийн сагсанд багтаж буй хослолуудаас ам.доллар Японы иений эсрэг 10.11 хувиар, Канад долларын эсрэг 5.12 хувь, Швед кроны эсрэг 4.69 хувиар тус тус сулрах хүлээлттэй байна.

## 2024 ОНД ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ТОП 10 ЭРСДЭЛ




*Эх сурвалж: EIU, World Economic Forum, The Economist Group, IMF, World Bank*

Ирэх онд хүлээгдэж буй эрсдэлүүд болон зах зээлд нөлөөлөх магадлалд АНУ болон Европын холбооны ерөнхийлөгчийн сонгууль багтсан байна.
Учир нь сонгуулийн дараа төрийн эрх мэдэл өөр засагт шилжих үед гадаад харилцаанд хэрэгжүүлж байсан бодлого өөрчлөгдөх эрсдэл үүсдэг.
Тухайлбал, 2018 онд АНУ-д Доналд Трамп засаглаж байх хугацаанд АНУ болон БНХАУ-ын хооронд гадаад худалдааны дайн үүсэж, тухайн жилд S&P 500 индекс 18 хувиар унаж байжээ.

# МОНГОЛ УЛСЫН
# ЭДИЙН ЗАСАГ
# 2024



# МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ

## МОНГОЛ УЛС 2024 ОН



**Н.Данзандагва**
*Арилжааны газрын захирал*

Монгол Улсын нүүрсний экспортын хэмжээ түүхэн дээд хэмжээнд хүрч, Оюу толгойн төслийн далд уурхайн бүтээн байгуулалт эхэлснээр уул уурхайн салбарын үйлдвэрлэл эдийн засгийн өсөлтийн цөм хэсгийг бүрдүүлж байна.

Мөн үйлчилгээний салбар тэр дундаа аялал жуулчлалын салбар хөгжиж буй нь эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөөг үзүүллээ.

Энэ оны эхний 3 улирлын байдлаар нэрлэсэн ДНБ 46.5 их наяд төгрөгт хүрч, эдийн засаг 6.9 хувиар өслөө.

**ЦАР ТАХЛЫН ДАРАА ХИЛ ГААЛЬ НЭЭГДСЭН, УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНҮҮДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ҮНЭ, УУЛ УУРХАЙН ЭКСПОРТ СЭРГЭСЭН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ТЭЛЭЛТ ЗЭРЭГ ХҮЧИН ЗҮЙЛС НЬ ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ ТҮРГЭСЭХ СУУРЬ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЛЭЭ.**

**ИЙНХҮҮ УУЛ УУРХАЙН САЛБАРЫН НӨЛӨӨГӨӨР ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ ТҮРГЭСЭЖ БУЙ Ч УУЛ УУРХАЙН БУС САЛБАРЫН ЭМЗЭГ БАЙДАЛ ҮРГЭЛЖИЛСЭЭР БАЙНА.**

### ДНБ, НЭРЛЭСЭН ҮНЭЭР (их наяд ₮)

*Эх сурвалж: www.1212.mn*




### ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, УЛИРЛААР (%)

*Эх сурвалж: www.1212.mn*



Өнгөрсөн 11-р сард УИХ-аар баталсан 2024 оны төсвийн бодлогын баримт бичигт ирэх 4 жилд 1 хүнд ногдох ДНБ-ийг 10.0 мянган ам.долларт хүргэх суурь нөхцөлийг бүрдүүлэхээр зорьж байна.

Уг зорилтын хүрээнд боомтын болон худалдааны сэргэлтийн бодлого, ажлын байр, хөдөлмөрийн зах зээлийг эрчимжүүлэх зэрэг бодлогуудыг хэрэгжүүлэх юм.

Мөн 3-р улирлын байдлаарх эдийн засгийн гүйцэтгэлээс үзэхэд, уул уурхайн бус салбарын идэвхжил харьцангуй сул байгаа нь эдийн засаг уул уурхайн салбараас хэт хамааралтай болж, уг салбарын мөчлөгийн хэлбэлзэлд улам ихээр өртөмтгий болсныг харуулж байна.

Цар тахлын дараах дэлхийн эдийн засагт үүсээд буй хамгийн том сорилт нь үнийн өсөлт, түүнийг дагасан бодлогын орчны хумигдмал байдлыг төв банкнууд, судалгааны байгууллагууд онцолж байна.

Хүлээлтийн хувьд улс орнуудын төв банкнууд инфляцыг бууруулбал макро түвшинд эдийн засгийг тэлэх, өсөлтийн хурдыг түргэсгэх, ажлын байр, хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг шийдвэрлэх боломжтойг тайлбарлаж байна.

Манай улсын хувьд макро бодлого, Засгийн газрын худалдан авалт, хөрөнгө оруулалтын суурь болох 2024 оны Төрөөс баримтлах мөнгөний бодлогын чиглэл, Төсвийг УИХ-аар батлуулсан.

Уг баримт бичгүүдээс үзэхэд Монголбанкнаас баталсан төсвийн хүрээнд томоохон хэмжээний бодлогын хөрөнгө оруулалт хэрэгжихээр байна.

Өөрөөр хэлбэл 2024 онд 13 хувийн түвшинд хадгалагдаж буй бодлогын хүүг бууруулах боломж нь төсвийн зардал, хөрөнгө оруулалтын урсгалаас ихээхэн хамаарна.

Өнгөрсөн 2 жил гаруйн хугацаанд 10-аас дээш хувийн түвшинд байсан инфляц сүүлийн сарууддад буурч, 10 сарын байдлаар 9.0 хувь хүртэл буураад байгаа юм.

Ийнхүү инфляц буурахад бензин, түлшнээс бусад бүтээгдэхүүн 3.2 нэгж хувиар, мах болон хатуу түлшнээс бусад барааны үнэ 4.5 хувиар тус тус буурсан нь голлох нөлөөллийг үзүүлжээ.

> Инфляц буурч буй ч одоогийн инфляцын 40 орчим хувь нь гурил, гурилан бүтээгдэхүүн (25 орчим хувь) болон мах, махан бүтээгдэхүүн (15 орчим хувь) байна.

## ХЭРЭГЛЭЭНИЙ САГСАН ДАХЬ БАРАА БҮТЭЭГДЭХҮҮНҮҮДИЙН ИНФЛЯЦИД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

*2023 оны 10 сарын байдлаар*

| | Бараа, үйлчилгээний бүлэг | Инфляцид үзүүлж буй хувь (%) | Хэрэглээний сагсан дахь хувийн жин (%) |
|---|---|---|---|
| **№** | **Ерөнхий индекс** | **9.0** | **100.0** |
| 1 | Хүнсний бараа, ундаа, ус | 4.0 | 44.2 |
| 2 | Согтууруулах ундаа, тамхи | 0.1 | 0.7 |
| 3 | Хувцас, бөс бараа, гутал | 0.9 | 9.9 |
| 4 | Орон сууц, ус, цахилгаан, түлш | 0.3 | 3.6 |
| 5 | Гэр ахуйн тавилга, бараа | 0.4 | 4.5 |
| 6 | Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ | 0.6 | 6.3 |
| 7 | Тээвэр | 0.1 | 1.1 |
| 8 | Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ | 0.0 | 0.2 |
| 9 | Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ | 0.1 | 1.0 |
| 10 | Боловсролын үйлчилгээ | 0.8 | 8.5 |
| 11 | Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ | 0.5 | 5.8 |
| 12 | Даатгал, Санхүүгийн үйлчилгээ | 0.0 | 0.3 |
| 13 | Бусад бараа, үйлчилгээ | 1.2 | 13.7 |

> БНХАУ-ын үл хөдлөх, аж үйлдвэрийн салбарт үүсээд буй уналттай холбоотойгоор тус улсын эдийн засгийн хүлээгдэж буй төлөв дордож байгаа нь түүхий эд, тэр дундаа Монгол Улсын экспортын голлох түүхий эдүүдийн ханшид сөргөөр нөлөөлөхөөр байна...,

Дэлхийн банкны судлаачдын тайлбарлаж буйгаар дунд хугацаанд хүнс, газрын тосны үнэ доогуур байгаа нь инфляцын дарамтыг бууруулж, уул уурхайн салбарт бизнес эрхлэгчдийн ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлөхөөр байна.

Олон улсын түүхий эдийн зах зээлийн төлөв тайлант оноос сулрахаар хүлээгдэж буй тул манай улсын экспортын орлогыг одоогийн түвшинд хадгалах, гүйцэтгэлийг өсгөхийн тулд экспортын биет хэмжээг нэмэгдүүлэх сорилт тулгарахаар байна.

**Алтны хилийн үнэ** (ам.доллар/грамм)
*Эх сурвалж: www.1212.mn*




**Алтны экспортын биет хэмжээ** (тн)
*Эх сурвалж: www.1212.mn*




**Нүүрсний хилийн үнэ** (ам.доллар/тн)
*Эх сурвалж: www.1212.mn*




**Нүүрсний экспортын биет хэмжээ** (сая тн)
*Эх сурвалж: www.1212.mn*



**Зэсийн хилийн үнэ** (ам.доллар/тн)
*Эх сурвалж: www.1212.mn*




**Зэсийн экспортын биет хэмжээ** (мян. тн)
*Эх сурвалж: www.1212.mn*




**Түүхий нефть** (мян. баррель)
*Эх сурвалж: www.1212.mn*




**Түүхий нефть, биет хэмжээ** (мян. баррел)
*Эх сурвалж: www.1212.mn*




Монгол Улсын хувьд улс хоорондын ачаа тээврийн өртөг нь импортын бүтээгдэхүүний үнэ, валютын урсгалд хүчтэй нөлөөлдөг.

Цар тахлын нөлөөгөөр тээврийн өртөг 2021 онд түүхэн дээд түвшинд хүрч нэмэгдсэнээс үүдэн импортын барааны тээврийн зардал огцом өссөн.

Тухайлбал, төлбөрийн тэнцлийн импортын ачаа тээврийн үйлчилгээний зардал 2015-2020 оны жилийн дундажтай харьцуулахад 2021 онд 2.5 дахин нэмэгдэж 405 сая ам.долларт хүрсэн бол 2022 онд 3.2 дахин өсөж 514 сая ам.долларт хүрсэн байна.

Тээврийн үйлчилгээний зардал нэмэгдэхэд 2 хөршөөс бусад улсуудаас худалдан авсан импортын бүтээгдэхүүний тээврийн зардал буюу холын тээвэрлэлтийн зардлын өсөлт хамгийн ихээр нөлөөлөхийг Монголбанкны судалгаа харуулж байна.

## Төлбөрийн тэнцэл 2023 онд ашигтай гарснаар, гадаад валютын албан нөөц өсөж, 4.9 тэрбум ам.долларт хүрлээ...,

Хилийн боомтуудын нэвтрүүлэх чадвар сайжирч, уул уурхайн голлох бүтээгдэхүүн (зэс, нүүрс г.м)-ын дэлхийн зах зээл дэх ханш өндөр байсны нөлөөгөөр 2023 оны 11 сарын байдлаар экспорт 11.8 тэрбум ам.доллар, импорт 8.4 тэрбум тэрбум ам.долларт тус тус хүрч, гадаад худалдааны тэнцэл 5.4 тэрбум ам.долларын ашигтай гарав.

Энэ нь төлбөрийн тэнцлийн данс 481.1 сая ам.долларын ашигтай гарах нөхцөлийг бүрдүүлжээ.

Мөн төлбөрийн тэнцлийн санхүүгийн данс ашигтай гарахад 2023 онд ГШХО -ын хэмжээ 1.2 тэрбум ам.долларт хүрсэн нь голлох нөлөөг үзүүлснээр төлбөрийн тэнцэл 963.5 сая ам.долларын ашигтай гараад байна.




*Эх сурвалж: Монгол Банк, www.1212.mn*

Гадаад валютын албан нөөцийн хэмжээ өсөж буй дотоодын валютын захыг тогтворжуулж, төгрөгийн ханш гадаад валютуудын эсрэг тогтвортой байхад нөлөөлж байна.

Төлбөрийн тэнцлийн гүйцэтгэлээс гадна Засгийн газар болон МИК, ММК зэрэг хувийн компаниудын олон улсад арилжаалсан ам.долларын бондын зарим хэсгийг дахин санхүүжилт байдлаар зохион байгуулж, валютын гадагшлах урсгалыг бууруулсан нь гадаад валютын албан нөөцийг өсгөж байна.

Ийнхүү албан нөөц өсөж 4.9 тэрбум ам.доллар болсон нь манай улсын валютын төлбөртэй импортын 6.5 сарын хэрэгцээг хангах үзүүлэлт болоод байна.

> Төв банкны бодлогын хүү сүүлийн 6 улирал дараалан 10 болон түүнээс дээш хувийн түвшинд хадгалагдаж байна...,

Глобал эдийн засгийн сэргэлт 2023 онд өмнөх 3 жилээс хурдассан. Гэвч зарим улс хооронд үүссэн зөрчилдөөнт нөхцөл байдалтай холбоотой геополитикийн асуудал, төв банкнуудын баримталж буй мөнгөний хатуу бодлогын нөлөөгөөр санхүүгийн эх үүсвэрийн өртөг өсөх болон БНХАУ-ын эдийн засгийн хүлээгдэж буй төлөв сул байгаа нь дотоодын мөнгөний бодлогын орчинд бодлогын хүүг бууруулах орон зайг хумьсаар байна.

## ШИГТГЭЭ: БОДЛОГЫН ХҮҮГИЙН ДИНАМИК, ӨӨРЧЛӨЛТИЙН СУУРЬ ШАЛТГААН




*Эх сурвалж: Монгол Банк*

## БОДЛОГЫН ХҮҮГ ӨӨРЧИЛСӨН ШАЛТГААН

- Инфляцын өөрчлөлт
- Төсвийн зардлын өсөлт
- Төсвийн гадуурх зардал
- Мөнгө тараалт (Сайн хөтөлбөр)
- Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн хэлбэлзэл

- Инфляцын өөрчлөлт
- Гадаад худалдааны агшилт
- Төсвийн гадуурх зардал
- Мөнгө тараалт (Сайн хөтөлбөр)
- Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн хэлбэлзэл

- Геопитикийн зөрчилдөөн
- Глобал эдийн засаг, санхүүгийн орчин дахь тодорхой бус байдал
- БНХАУ-ын эдийн засгийн хүлээлт сул
- Түүхий эдийн үнийн 2024 оны төлөв доогуур
- Хэрэглээний зээлийн өсөлт

Монголбанкнаас хэрэглээний зээл өнгөрсөн оноос нэмэгдсэн нь өрхүүдийн санхүүд дарамт нэмэхийн зэрэгцээ импортыг өдөөх хандлагатай байна гэж мэдээлэв.

Энэ нь импортыг урамшуулах, үнийн өсөлтийг эрчимжүүлэх, бизнесийн зээл олголтыг хумих зэрэг эрсдэлийг дагуулахаар байна.

Ийнхүү төв банкнаас бодлогын хүүг 2023 онд 4 удаа хэвээр хадгалах шийдвэр гарч, өндөр түвшинд хадгалсаар байгаа нь санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний хүү буурах нөхцөл бүрдэхэд сөргөөр нөлөөлсөөр байна.

Мөн сүүлийн саруудад арилжааны банкнуудын зүгээс шинээр татаж буй хадгаламжид өндөр өгөөж амлаж буй нь хүүгийн түвшинг өсгөж байна.

Тухайлбал, 2023 оны 10-11 сард арилжааны банкнуудын шинээр татан төвлөрүүлж буй хадгаламжийн хүү өмнөх 3 улирлын дунджаас 0.9 нэгж хувиар өсжээ.

**Шинээр олгосон зээлийн ЖДХ (%)**
*Эх сурвалж: www.mongolbank.mn*




**Шинээр татсан хадгаламжийн ЖДХ (%)**
*Эх сурвалж: www.mongolbank.mn*




Зээлийн хүүгийн хувьд шинээр олгож буй төгрөгийн зээлийн хүү энэ оны эхний 11 сарын туршид 16.2-16.9 хувьд хэлбэлзэж байгаа бол валютын хүү сүүлийн хоёр сард өсөж 11.3 хувьд хүрээд байна.

> Тайлант онд төлбөрийн тэнцэл ашигтай гарсны нөлөөгөөр ГВАН өмнөх жилээс өссөн нь мөнгөний нийлүүлэлт өсөх суурь нөхцөлийг бүрдүүлж байна...,

Гадаад худалдаа, урсгал тэнцлийн эерэг гүйцэтгэлийн нөлөөгөөр төлбөрийн тэнцэл ашигтай гарч байгаа нь ГВАН өсөхөд нөлөөллөө.

Үүний үр дүнд сүүлийн саруудад мөнгөний нийлүүлэлт (М2 мөнгө) өсөж байна.

### М2 мөнгө, бүрэлдэхүүн хэсгүүдээр
(их наяд ₮)
*Эх сурвалж: www.mongolbank.mn*




### М2 мөнгө, жилийн өсөлт (%)
*2023 оны 11 сар*




Энэ оны 11 сарын байдлаар мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт 19.3 хувь байгаа нь өмнөх 8 улирлын дунджаас 2 дахин өндөр үзүүлэлт юм.

М2 мөнгөний өсөлтийг төгрөгийн эх үүсвэр голлон бүрдүүлж байгаа бөгөөд уг өсөлтийн 11.1 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 2.9 нэгж хувийг төгрөгийн харилцах тус тус бүрдүүлжээ.

Валютын эх үүсвэрийн хувьд валютын хадгаламжийн нөлөө бууралттай гарсан бол валютын харилцахын М2 мөнгөний өсөлт дэх оролцоо 5.5 нэгж хувьд хүрсэн байна.

Өмнөх онд өндөр өсөлттэй байсан эх үүсвэрийн долларжилт буурч, 2023 оны эхний хагас жилд 30.4 хувьд хүрч, 2024 оны төгрөгийн ханш ам.долларын эсрэг тогтвортой байвал долларжилт буурах хүлээлттэй байна.

# ӨСӨЖ БУЙ МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ



**Р. Дарханбаяр**
*Ахлах шинжээч, Хөрөнгө удирдлага, судалгааны газар*

**2023 ОНД МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ 10.2 ИХ НАЯД ТӨГРӨГТ ХҮРЧ ӨССӨН БА ТОП-20 ИНДЕКС ОНЫ ЭХНЭЭС 4.8 ХУВИАР ӨССӨН БАЙНА.**

**СҮҮЛИЙН 1 ЖИЛД ТАВАНТОЛГОЙ ХК (MSE:TTL) +89.51%, ЛЭНДМН ББСБ ХК (MSE:LEND) +76.24%, ИНВЕСКОР ББСБ (MSE:INV) +43.16% БУЮУ ХАМГИЙН ӨНДӨР ӨСӨЛТТЭЙ БАЙНА.**

### ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ӨСӨВ

Хөрөнгийн зах зээлийн үнэлгээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 их наяд 502 тэрбум төгрөг буюу 2 дахин өсөж, 10 их наяд 289 тэрбум төгрөг болсон байна.

Зах зээлийн үнэлгээ өсөхөд системийн нөлөө бүхий 5 банк хөрөнгийн зах зээлээс 447 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн нь нөлөөлжээ.

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ /ИХ НАЯД ТӨГРӨГ/

*Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж*



## ХУВЬЦААНЫ ӨСӨЛТИЙГ ХЯЗГААРЛАЖ БАЙСАН ХҮЧИН ЗҮЙЛСИЙН НӨЛӨӨ АРИЛЖ БАЙНА

Хэт өндөр хүүгийн түвшин ирэх онд буурах хүлээлттэй байна.

Монголбанкны зүгээс инфляцыг бууруулах зорилгоор мөнгөний бодлогыг чангатгаж, бодлогын хүүг 13 хувьд хүргэж 7 хувиар нэмснээр бондын хүү өсөхөд нөлөөлж, 2023 онд эрсдэлгүй хөрөнгө оруулалтад хөрөнгө оруулах мөнгөний урсгалыг нэмлээ.

Ингэснээр хувьцааны зах зээл хямдрах суурь нөхцөлийг бүрдүүлжээ.

2024 онд инфляцын түвшин буурах хүлээлттэй байна. Мөн дэлхий дахинд болон дотоодод бодлогын хүү буурах хүлээлт үүсээд байгаа юм.

2022 онд бодлогын хүүг бага багаар өсгөсөн ч иргэдийн хадгаламж өсөөгүй буюу үнийн өсөлтөөс шалтгаалж хадгалах боломж багассан.

Харин 2023 он гарснаар хадгаламж, харилцахын дүн өссөн байна. Иймд 2024 онд бодлогын хүү буурвал хадгаламжаас хөрөнгийн зах зээлд орох мөнгөний урсгал тэлэх хүлээлттэй байна.

### ИРГЭДИЙН ТӨГРӨГИЙН ХАДГАЛАМЖИЙН ӨСӨЛТ
/ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕТЭЙ ХАРЬЦУУЛСНААР/

*Эх сурвалж: Монголбанк*




## ХУВЬЦААНЫ НИЙЛҮҮЛЭЛТ ИХ БАЙВ

Аливаа бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт өсөх нь тухайн бараа бүтээгдэхүүний үнийг бууруулахад нөлөөлдөг эдийн засгийн суурь ойлголт бий.

Тэгвэл 2022-2023 онд 479.3 тэрбум төгрөгийн IPO гарсан нь өмнөх 10 жилд гарсан нийт IPO-оос 2.4 дахин их дүнтэй байна. Өөрөөр хэлбэл хувьцааны нийлүүлэлт ихэссэн юм.

Банкны IPO-д давхардсан тоогоор 70 мянган жижиг хөрөнгө оруулагч оролцжээ.

## ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ ИДЭВХ НЭМЭГДЭВ

2023 оны эхний 3 улирлын байдлаар Монголын Хөрөнгийн Биржээр хувьцааны анхдагч болон хоёрдогч зах зээлийн нийт 467.0 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэв.

Мөн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаа 44.7 тэрбум, компанийн бондын анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаа 97.1 тэрбум төгрөгөөр тус тус арилжаалагдаж нийт 614.2 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна.

## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ ИДЭВХ /тэрбум төгрөг/




*Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж*

## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД ТЭЛЭХ ХАНГАЛТТАЙ ОРОН ЗАЙ БИЙ

Хөгжингүй орнуудын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ ДНБ-ий 100-200 хувьтай тэнцэхүйц өндөр байдаг бол хөгжиж буй орнуудын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ ДНБ-ий 20-40 хувьтай л тэнцэж байна.

## УЛС ОРНУУДЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ДНБ-Д ЭЗЛЭХ ХУВЬ /БАФФЕТ ИНДИКАТОР/




*Тэмдэглэл: Ханшийг 2023.12.21 -ний өдрийн байдлаар*

*Эх сурвалж: Statista, ҮСХ, Монголын Хөрөнгийн Бирж*

Дотоодын хөрөнгийн зах зээл дунд хугацаанд тэлэх суурь нөхцөл макро эдийн засаг болон зохицуулалтын орчны хүрээнд бүрдсэн байна.

### ЗОХИЦУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНҮҮДЭЭС ДУРДВАЛ:

- Сангийн яам дотоодын зах зээлд Засгийн газрын бонд гаргах зохицуулалтын болон дэд бүтцийн суурь ажлуудыг төлөвлөж буйгаа мэдэгдсэн. Түүнчлэн нийслэл, орон нутгийн бондууд гарах боломж бүрдэж байгаа нь бондын зах зээл үсрэнгүй сэргэх суурь нөхцөл болж байна.

- Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 244 дүгээр тогтоолын дагуу төрийн өмчийн компаниуд IPO хийх хүлээлттэй байна.

- Санхүүгийн Зохицуулах Хороо болон МҮХАҮТ-ын хамтын бодлогын арга хэмжээний хөтөлбөрийн хүрээнд ТОП 100 ААН-ийг IPO гаргахад дэмжих, суурь нөхцөлийг бүрдүүлснээр томоохон компаниуд зах зээлд гарах хүлээлттэй байна.

- Уул уурхайн зэс болон ховор метал зэрэг үнэт металиудыг Монголын Хөрөнгийн Биржийн харьяа Уул Уурхайн Бүтээгдэхүүний Биржээр дамжуулан арилжаалах боломжтой болов.

### БАНКНУУДЫН ХУВЬЦААНД ӨГӨХ ДҮГНЭЛТ

Системийн нөлөө бүхий банкнуудын IPO хуулийн хугацаандаа буюу 2023 оны 6 сарын 30-ны өдрөөс өмнө гарч олон нийтээс 446.8 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн.

Гэвч IPO хийснээс хойш нийт банкнуудын хувьцааны ханш дунджаар 17.5 хувиар уналаа.

### БАНКНЫ ХУВЬЦААНУУДЫН ХАНШИЙН ХЭЛБЭЛЗЭЛ
/IPO ГАРСНААС ХОЙШ/




*Тэмдэглэл: Ханшийг 2023.12.01 -ний өдрийн байдлаар* *Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж*

# БАНКНУУДЫН ХУВЬЦААНЫ ХАНШ ЯАГААД УНАВ?

### БОГИНО ХУГАЦААНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД ХУВЬЦААГАА ЗАРЛАА

Системийн банкнуудын IPO-д давхардсан тоогоор 70.2 мянган жижиг хөрөнгө оруулагч оролцсон бол 67.0 мянган жижиг хөрөнгө оруулагч үлджээ. Өөрөөр хэлбэл, богино хугацааны огцом өсөлтөөс ашиг хүртэх гэсэн хөрөнгө оруулагчид хувьцаагаа зарж гарсан байна.

### ЖИЖИГ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТОО
(стратегийн бус хувьцаа эзэмшигчид)

| | Хоёрдогч арилжаа эхлэхэд | 2023.12.01 | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Голомт Банк | 20,770 | 19,617 | -1,153 |
| Хаан Банк | 29,088 | 26,094 | -2,994 |
| Худалдаа Хөгжлийн Банк | 2,377 | 2,207 | -170 |
| Төрийн Банк | 7,290 | 8,449 | 1,159 |
| Хас Банк | 10,708 | 10,782 | 74 |

*Эх сурвалж: Маркет Инфо*

### ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХУВЬЦААНЫ НИЙЛҮҮЛЭЛТ СҮҮЛИЙН 1 ЖИЛД ӨНДӨР БАЙВ

Сүүлийн 12 сард гарсан нийт **IPO** нь олон нийтээс **479.3** тэрбум төгрөгийг татан төвлөрүүлжээ. Харин 2015 оноос 2022 оны 8 сарыг хүртэл **197.8** тэрбум төгрөгийн **IPO** хийгдсэн байна.

### ХЭТ ХАТУУ МӨНГӨНИЙ БОДЛОГО

Монголбанкны зүгээс инфляцыг бууруулах зорилтын хүрээнд мөнгөний бодлогыг чангатгаж бодлогын хүүг 7 хувиар нэмэгдүүлснээр бондын хүү өсөж, эрсдэлгүй хөрөнгө оруулалтад хөрөнгө оруулах мөнгөний урсгал нэмэгдлээ.

# АЛЬ БАНКНЫ ҮНЭЛГЭЭ ЗОХИСТОЙ ХУВЬЦАА НЬ ӨСӨХ БОЛОМЖТОЙ ВЭ?

## ЭХЛЭЭД СУУРЬ ТӨСӨӨЛӨЛ

Банк, санхүүгийн байгууллагуудын үнэлгээнд ашиглагддаг хамгийн чухал үзүүлэлт нь өөрийн хөрөнгийн балансын үнэлгээ юм.

Учир нь хэлбэлзэл багатай аливаа санхүүгийн хөрөнгүүдийн үнэлгээ нь бодит тайланд тусгагдаж буй үнэлгээнээс хол зөрдөггүй.

Иймд тайланд тусгагдсан өөрийн хөрөнгийн үнэлгээг зах зээлийн үнэлгээтэй нь харьцуулж, зах зээлийн үнэлгээ нь өөрийн хөрөнгийн үнэлгээнээс бага бол хямдаар үнэлэгдсэн гэж үздэг.

Мөн үүнийг P/B харьцаа буюу үнэ дансны үнийн харьцаа 1-ээс бага байна гэж төсөөлж болно.

2023 оны 12 сарын 1 өдрийн байдлаар өөрийн хөрөнгөөс багаар үнэлэгдсэн 2 банк буй нь Голомт Банк ХК болон Төрийн Банк ХК-ийн хувьцаа юм.

## БАНКНУУДЫН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ БА ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХАРЬЦУУЛАЛТ /ТЭРБУМ ТӨГРӨГ/




*Тэмдэглэл: Ханшийг 2023.12.01 -ний өдрийн байдлаар*

## ҮНЭЛГЭЭНИЙ ГОЛЛОХ ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮДЭЭР ЖИШИХ НЬ

2023 оны 12 сарын 1 өдрийн байдлаар системийн нөлөө бүхий банкнуудын дундаж P/E харьцаа 4.77, P/B харьцаа 0.91 байна.

Энэ нь МХБ-ийн ТОП-20 индексэд багтдаг бусад компаниудын дунджаас бага үзүүлэлт юм.

Тэр дундаа Голомт Банк болон Төрийн банкнуудын P/B харьцаа 1.0-ээс бага буюу 0.67, 0.77 байна.

## БАНКНУУДЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХАРЬЦУУЛАЛТ

*Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж*







*Тэмдэглэл: Ханшийг 2023.12.01 -ний өдрийн байдлаар*

## ЭЦЭСТ НЬ БУСАД ХҮЧИН ЗҮЙЛС

Банкнуудын өөрийн хөрөнгийн өсөлт нь эдийн засгийн өсөлттэй 0.9 корреляцийн хамааралтай буюу бараг шууд хамааралтай байна.

Иймд ирэх 2024-2025 оны эдийн засгийн төлөв нь банкны ашигт ажиллагаа, хувьцааны ханшийн гүйцэтгэлд нөлөөлөхөөр байна.

ОУВС-ийн төсөөллөөр Монгол Улсын 2024 оны эдийн засгийн өсөлтийн төлөв 4.5%-тай байгаа нь дэлхийн эдийн засгийн өсөлтөөс 1.4 хувиар өндөр байна.

# ГОЛОМТ БАНК
*Сайн сайхныг санхүүжүүлнэ*



**С.Дашням**
*Хөрөнгө оруулалтын шинжээч,*
*Хөрөнгө оруулалтын газар*

| Хувьцааны арилжааны мэдээлэл | |
|---|---|
| 2023 оны 12 сарын 22 | MSE:GLMT |
| Хаалтын ханш | ₮ 840.8 |
| 52 долоо хоног | ₮ 812.35 – 1,288 |
| Нийт гаргасан тоо ширхэг | 808,657,306 |
| Зах зээлийн үнэлгээ | ₮ 679,878,630,020 |

## ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ ТҮҮХ

*Эх сурвалж: МХБ*




## ГОЛЛОХ ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД*

*Эх сурвалж: МХБ, Голомт Капитал ҮЦК тооцоолол*

| | |
|---|---|
| Үнэ-ашгийн харьцаа (P/E) | 4.5 |
| Үнэ-дансны үнийн харьцаа (P/B) | 0.76 |
| Нэгж хувьцаанд ногдох ашиг | ₮150 |
| Ногдол ашгийн өгөөж | 9.2% |

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ




## КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

1995 онд үүсгэн байгуулагдсан Монгол Улсын ууган арилжааны банкнуудын нэг Голомт Банк ХК нь салбартаа тэргүүлэгч байрь суурьтай, олон улсад танигдсан нэр хүндтэй, итгэлтэй, найдвартай банк болон төлөвшжээ.
Тус банкны харилцагчдадаа үзүүлж буй үйлчилгээ, хэрэгжүүлж буй бүхий л санаачилга, шийдлүүд нь Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд үнэ цэнийг бүтээсээр ирсэн жишиг тогтоогч банк юм.

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ

2023 оны 3-р улирлын байдлаар Голомт Банк ХК-ийн P/E харьцаа 4.5, P/B харьцаа 0.76 байна. P/E харьцаанаас харвал МХБ-ийн 1 дүгээр ангиллын хувьцаануудын дундаж P/E харьцаа 9 байгаагаас 2.0 дахин бага байна.
Харин P/B харьцаа 0.76 байгаа нь Голомт Банк ХК нь өөрийн балансад тусгагдсан эздийн өмчийн дүнгээс 24% хямдралтай арилжаалагдаж буйг илтгэж байна.

## КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Голомт Банк ХК нь сая гаруй харилцагч, 2300 гаруй ажилчид, 100 гаруй салбараараа харилцагчдадаа санхүүгийн цогц үйлчилгээг үзүүлж байна.
2023 оны байдлаар Голомт Банк ХК нь нийт 9.6 их наяд төгрөгийн хөрөнгөтэйгээр банкны системийн 20.3 хувийг дангаар бүрдүүлж, цэвэр ашгийн дүнгээр 2-т эрэмблэгдэж байна.

## НОГДОЛ АШГИЙН ӨГӨӨЖ (9.2-15.2%)

Голомт Банк ХК нь 2023 онд нэгж хувьцаанд 50 төгрөгийн ногдол ашгийг тараасан нь 2022 оны нийт цэвэр ашигтай харьцуулбал 40% юм. Иймд Голомт Банк ХК IPO танилцуулгад тусгасны дагуу цэвэр ашгийн 40% хүртэлхийг ногдол ашиг болгон хөрөнгө оруулагчдадаа тараах байна. Голомт Банкны хаалтын ханшид тулгуурлан ногдол ашгийн өгөөжийг ирэх жилүүдэд төсөөлбөл 9.0%-13.8% байна.

## САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

2023 оны эхний 3 улирлын байдлаар Голомт Банк ХК нь 448.8 тэрбум төгрөгийн хүүгийн орлого, 9.6 их наяд төгрөгийн нийт хөрөнгөтэй ажилласан нь 2022 оны 3-р улирлын үзүүлэлтүүдээс харгалзан 47 хувь, 7.1 хувиар өссөн байна. Түүнчлэн активын чанарын удирдлагыг амжилттай хэрэгжүүлснээр эрсдэлийн сангийн зардал өмнөх оны мөн үеэс 76 хувиар буурч 25.6 тэрбум төгрөгт хүрсэн ба **цэвэр ашиг өмнөх оны мөн үеэс 66 хувиар өссөн.**

## ХЭТИЙН ТӨЛӨВ

Зах зээл дээрх хүүгийн түвшин 2024 оны эхний хагас жилд ч өндөр хэвээр үргэлжлэх төлөвтэй байгаа тул хүүгийн орлого өсөх хандлагатай байгаа бол зээлийн хүү болон валютын ханшийн хэлбэлзэл тогтвортой байж, СВОП-ын үнэ цэний хэлбэлзэл болон зээлийн сангийн зардал бага байх төлөвтэй байна.
Эх үүсвэрийн өсөлтийн 68 хувийг Корпорэйт сегмент бүрдүүлж байна.
Мөн 2024-2026 оны эдийн засгийн өсөлтийн эерэг хүлээлттэй холбоотойгоор эх үүсвэрийн өсөлт өндөр байх хүлээлттэй байна.

## IPO АМЛАЛТ БА ГҮЙЦЭТГЭЛ

- Голомт банкны ашигт ажиллагаа 2022 онтой харьцуулахад 4.6 дахин өндөр, IPO төлөвлөгөөтэй харьцуулахад 55% илүү сайн гарсан.
- 2023 оны эхний 3 улирлын байдлаар банкны ашиг IPO-ийн төлөвлөгөөг давуулан биелүүлсэн буюу 131 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай байна.

### Ашгийн төсөөлөл ба гүйцэтгэл (тэрбум төгрөг)




* IPO танилцуулгад тусгасан төлөвлөгөө
** 2022 оны урьдчилсан гүйцэтгэл

### Нийт хөрөнгө (тэрбум төгрөг)




### Өөрийн хөрөнгө (тэрбум төгрөг)




### Хүүгийн орлого (тэрбум төгрөг)




### Цэвэр ашиг (тэрбум төгрөг)




Эх сурвалж: Голомт Банк ХК,
Голомт Капитал ҮЦК тооцоолол

# МОНОС ХҮНС



**С.Дашням**
*Хөрөнгө оруулалтын шинжээч,*
*Хөрөнгө оруулалтын газар*

| Хувьцааны арилжааны мэдээлэл | |
|---|---|
| 2023 оны 12-р сарын 18 | MSE: MFC |
| Хаалтын ханш | ₮ 98.02 |
| 52 долоо хоног | ₮ 97.54 – 124.74 |
| Нийт гаргасан тоо ширхэг | 408,850,428 |
| Зах зээлийн үнэлгээ | ₮ 40,075,518,952.56 |

## ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ ТҮҮХ

*Эх сурвалж: МХБ*




## ГОЛЛОХ ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД*

*Эх сурвалж: МХБ, Голомт Капитал ҮЦК тооцоолол*

| | |
|---|---|
| Үнэ-ашгийн харьцаа (P/E) | 19.16 |
| Үнэ-дансны үнийн харьцаа (P/B) | 2.18 |
| Үнэ-борлуулалтын харьцаа (P/S) | 1.42 |
| Ноогдол ашгийн өгөөж | 2.45% |

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

*Эх сурвалж: МХБ*




## КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

Монос Хүнс ХК нь Монос Группийн 36 салбар компаниудын нэг бөгөөд 2012 онд үүсгэн байгуулагдсан.
Монос Хүнс ХК нь эрүүл мэндийн хүнс болон хүнсний нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бөгөөд 2019 онд Монголын Хөрөнгийн Биржид бүртгэгдсэн.

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ

Монос Хүнс ХК-ийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчээр Монос Группийн Ерөнхийлөгч Лувсангийн Хүрэлбаатар нийт хувьцааны 286,195,300 буюу 70 хувийг нь эзэмшдэг бол үлдсэн хувь нь олон нийтийн эзэмшилд байдаг.

## КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монос Хүнс ХК нийт 13 брэндийн 71 төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бөгөөд 2017 оноос олон улсын ISO9001:2015 болон хүнсний аюулгүй байдлын HACCP нэвтрүүлэх төслийн ажлыг эхлүүлжээ.
Монос Хүнс ХК нь 2022 оноос ОХУ, БНХАУ, АНУ, БНСУ, БНКУ-ын зах зээлд нэвтрэхээр ажиллаж байна. Одоогоор Монос Хүнс ХК нь ОХУ руу Экос уусдаг цай, Япон улс руу Бэрри Бит үрэл экспортолдог.
Мөн ОХУ-ын TSC Food Products RU компани нь Монос Хүнс ХК-тай хамтран "Милино" брэндийн тарагтай ааруултай үрэл бүтээгдэхүүнийг хөгжүүлэн ОХУ-ын зах зээлд нийлүүлдэг.

## БОРЛУУЛАЛТ

- **Эрүүл мэндийн бүтээгдэхүүн: Vitos Цэнэг, Vitos Shot, Увдист тос**
- **Цай: Энхжин, Эко уусдаг цай, Tastea, 100 наслаарай**
- **Ус ундаа: Экос, Увдист өтгөрүүлсэн шүүс**
- **Хүүхдийн бүтээгдэхүүн: BerryVit, Тугал, Аами&Таами**

## САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

2023 оны 2-р улирлын байдлаар Монос Хүнс ХК-ийн борлуулалтын орлого 16.5 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулбал 18.69 хувийн өсөлтийг үзүүлсэн бол цэвэр ашиг өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 39.47 хувиар өсөж 2.1 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Компанийн борлуулалтын орлого 2019-2022 онд жилд дунджаар 44.08 хувийн өсөлттэй байсан бол тус хугацаанд цэвэр ашиг жилийн 61.13 хувийн өсөлтийг үзүүлсэн.

Тус компанийн нийт хөрөнгийн хэмжээ 2023 оны 2-р улиралд 44.9 тэрбум төгрөгт хүрч 2022 оны жилийн эцсийн үзүүлэлтийг 23.06 хувиар давсан байна.

Сүүлийн улирлын байдлаар тус компанийн нэгж хувьцаанд ногдох ашиг 5.12 төгрөг байгаа бөгөөд 2022 оны цэвэр ашгаас Монос Хүнс ХК нэгж хувьцаанд 2.4 төгрөг тараасан.

### БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО (тэрбум төгрөг)




Голлох харьцаа үзүүлэлтүүд* - Хувьцааны ханшийг 2023 оны 12-р сарын 18-ны өдрийн хаалтын ханшаар, санхүүгийн үзүүлэлтийг 2023 оны 2-р улирлын тайлангаар болон жилчилсэн дүнгээр, ногдол ашгийн өгөөжийг 2022 оны үйл ажиллагааны үр дүнд үндэслэн тус тус тооцов.

### ЦЭВЭР АШИГ (тэрбум төгрөг)




### НИЙТ ХӨРӨНГӨ (тэрбум төгрөг)




### ХӨРӨНГИЙН БҮТЭЦ




### САНХҮҮЖИЛТИЙН БҮТЭЦ




Эх сурвалж: Голомт Банк ХК, Голомт Капитал ҮЦК тооцоолол

ТҮМЭН ШУВУУТ ®



**А.Намуун**
*Хөрөнгө оруулалтын шинжээч,*
*Хөрөнгө оруулалтын газар*

| Хувьцааны арилжааны мэдээлэл | |
|---|---|
| 2023 оны 12-р сарын 13 | MSE: TUM |
| Хаалтын ханш (2023.12.13) | ₮ 326.28 |
| 52 долоо хоног | ₮ 300.00-384.81 |
| Нийт гаргасан тоо ширхэг | 200,000,000 |
| Зах зээлийн үнэлгээ | ₮ 65,256,000,000.00 |

## ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ ТҮҮХ

*Эх сурвалж: МХБ*




## ГОЛЛОХ ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД*

| | |
|---|---|
| Үнэ-ашгийн харьцаа TTM (P/E) | 7.06 |
| Үнэ-дансны үнийн харьцаа TTM (P/B) | 1.60 |
| Үнэ-борлуулалтын харьцаа TTM (P/S) | 1.19 |
| Ноогдол ашгийн өгөөж | 3.08% |

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

*Эх сурвалж: МХБ*




## КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

Түмэн Шувуут ХК нь 2004 онд 20,000 өндөглөгч тахиатайгаар үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд өнөөг хүртэл шувууны аж ахуйн үйл ажиллагааг тогтвортой эрхэлж буй салбартаа тэргүүлэгч компани юм.
Тус компани нь ХАА-н цогц шийдлийг хэрэгжүүлэхээр үйл ажиллагаагаа өргөжүүлж, малын тэжээлийн үйлдвэр, өндөгний сав баглааны үйлдвэр, органик бордооны үйлдвэр, усалгаатай газар тариаланг тус тус эрхэлж байна.

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ

Түмэн Шувуут ХК-ийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн хувьд ТУЗ-ийн дарга болох Ломбын Эрхэмбаяр, ТУЗ-ийн гишүүн Эрхэмбаярын Баяржаргал, Жигжидийн Болд, Балайн Тунгалаг нар харгалзан 30.00%, 10.00%, 10.00%, 30.02%-ийг эзэмшдэг.
Тус компани нийт 344 сая хувьцаа гаргаснаас 99.73 хувь нь нээлттэй арилжаалагддаг.

## КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Түмэн Шувуут ХК-ийн үйл ажиллагаа нь Агрофийд тэжээлийн үйлдвэр, Органик бордооны үйлдвэр, Мал аж ахуй, Агрофийд бордоо ХК, Усжуулах ХК, Өндөгний сав баглааны үйлдвэр, Түмэн шувуут 1,2-р үйлдвэртэй.
100 хувь дотоодын хөрөнгө оруулалттай нийт 600 мянган өндөглөгч тахиатай, 200 мянган дэгдээхийтэй, нэг ээлжиндээ 153 мянган ширхэг өндөг дарах хүчин чадал бүхий инкубаторын цехтэйгээр үйл ажиллагаагаа эрхэлж байна.

## БОРЛУУЛАЛТ

**Өндөг үйлдвэрлэл:** Түмэн Шувуут ХК нь 2022 онд нийт 97.7 сая ширхэг өндөг үйлдвэрлэж зах зээлд нийлүүлсэн бол 2023 оны эхний хагаст нийт 54 сая ширхэг өндөг үйлдвэрлэсэн. Оны эцэс гэхэд 117 сая ширхэг өндөг үйлдвэрлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна. Мөн дэгдээхэйн нэг байр нэмж барихаар ажиллаж байна.

**Малын тэжээл:** Тус компани 2023 оны эхний хагас жилд 12.7 тонн тэжээл үйлдвэрлэсэн байна.

Компанийн борлуулалт 2023 оны эхний хагас жилийн байдлаар өнгөрсөн оны мөн үеэс 40.7 хувиар өсөж 29.7 тэрбум төгрөгт, цэвэр ашиг 2023 оны эхний хагас жилийн байдлаар өнгөрсөн оны мөн үеэс 54.4 хувиар өсөж 5.76 тэрбум төгрөгт хүрчээ.

## САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

2019-2022 онд компанийн борлуулалтын орлого жилд дунджаар 22.96 хувийн өсөлттэй байсан бол цэвэр ашиг жилийн 22.00 хувиар өссөн.

2022 оны эцэст компанийн цэвэр ашгийн маржин 15.5 хувьтай байсан бол оны эхний хагас жилийн байдлаар 1.5 хувьд хүрснээр ашигт ажиллагаа сайжирчээ.

Тус компанийн нийт хөрөнгийн хэмжээ 2023 оны эхний хагас жилд 65.77 тэрбум төгрөгт хүрч 2022 оны жилийн эцсийн үзүүлэлтээс 25.46 хувиар өссөн. 2023 оны 2-р улирлын байдлаар тус компанийн эргэлтийн хөрөнгө 70.49 хувиар өсөж эргэлтийн харьцаа 0.92 болсноор балансын үзүүлэлт эрүүлжиж эхэлж байна.

Өр төлбөр 62.65 хувиар өссөн ч өрийн харьцаа 38.4 хувь буюу эрүүл түвшинд хадгалагдаж байна.

Компани 2022 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 10.7 төгрөгийн ногдол ашиг тараасан байна.

## БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО (тэрбум төгрөг)




## ЦЭВЭР АШИГ (тэрбум төгрөг)




## НИЙТ ХӨРӨНГӨ (тэрбум төгрөг)




## ХӨРӨНГИЙН БҮТЭЦ




## САНХҮҮЖИЛТИЙН БҮТЭЦ




*Эх сурвалж: Голомт Банк ХК, Голомт Капитал ҮЦК тооцоолол*

Голлох харьцаа үзүүлэлтүүд* - Хувьцааны ханшийг 2023 оны 12-р сарын 13-ний өдрийн хаалтын ханшаар, санхүүгийн үзүүлэлтийг 2023 оны 2-р улирлын тайлангаар болон жилчилсэн дүнгээр, ногдол ашгийн өгөөжийг 2022 оны үйл ажиллагааны үр дүнд үндэслэн тус тус тооцов

# БОНДЫН ЗАХ ЗЭЭЛД

## ХӨЛ ТАВЬЖ АМЖСАН УУ?



# ГОЛОМТ КАПИТАЛЫН САНАЛ БОЛГОЖ БУЙ БОНДУУД

## ДУНДАЖ ӨГӨӨЖ –“20.0%”

2023 он гарснаас хойш Биржийн бус зах зээлд нийт 164.0 тэрбум төгрөгийн бонд гарснаас Голомт Капитал ҮЦК нь 132.0 тэрбум төгрөгийн бондыг татан төвлөрүүлээд байна.

Түүнчлэн, Биржийн бус зах зээлд гарсан бондуудын дундаж өгөөж 19.0 хувь байсан бол Голомт Капитал ҮЦК-ийн гаргасан бондуудын өгөөж 20.0 хувьтай байгаа нь хадгаламжийн хүүнээс 1.6 дахин өндөр өгөөжтэй хөрөнгө оруулалт юм.

### ГОЛОМТ КАПИТАЛЫН САНАЛ БОЛГОЖ БУЙ БОНДУУДЫН ХАРЬЦУУЛАЛТ

| | ХААЛТТАЙ БОНД | НЭЭЛТТЭЙ БОНД | ХБҮЦ |
|---|---|---|---|
| Дундаж хүү | 19.00% | 18.00% | 18.00% |
| Татвар | 10% | 5% | 5% |
| Татварын дараах өгөөж | 17.10% | 17.10% | 17.10% |
| Хугацаа | 12-24 сар | 12-24 сар | 12-24 сар |
| Барьцаа | Үл хөдлөх хөрөнгө, хувьцаа, хөндлөнгийн баталгаа, хөдлөх хөрөнгүүд (>130%) | | Авлагын мөнгөн урсгал ( >110%) |

*Тэмдэглэл: Хүү болон өгөөжийн түвшин 2024 оны 1 сарын байдлаар*

# ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС

## ХАМГИЙН ЭРСДЭЛ БАГА

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь тогтмол орлого бий болгох хамгийн чанартай зээлүүдийг багцалж, тэдгээрийн орлогын мөнгөн урсгалд суурилсан үнэт цаас юм.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь бондтой харьцуулахад эргэн төлөгдөх мөнгөн урсгал нь үе шаттай тул хөрвөх чадвар илүү сайн байдаг ба компанийн дампуурлаас ангид тул үйл ажиллагаанаас нь шалтгаалах эрсдэл багатай.

2023 оны байдлаар Монголын Хөрөнгийн Биржид нийт 9 хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас бүртгэгджээ. ХБҮЦ /Хөрөнгөөр Баталгаажсан Үнэт Цаас/ нь бондтой харьцуулахад эргэн төлөгдөх мөнгөн урсгал нь улирал тутам тул хөрвөх чадвар илүү сайн байдаг.

Голомт Капитал ҮЦК нь 2022 оны 10 сард Биржийн Бус Зах Зээлийн анхны Нөмөр ХБҮЦ-ыг олон нийтэд санал болгосон бол 2023 онд Бэрс-2 ХБҮЦ-ыг олон нийтэд санал болгосон юм.

## ҮНЭТ ЦААСНЫ ЭРСДЭЛ ӨГӨӨЖИЙН ТҮВШИН




## БОНДОД ХӨРӨНГӨ ОРУУЛАХАД ТОХИРОМЖТОЙ ЦАГ | ХҮҮГИЙН ӨСӨЛТ

Монголбанкны бодлогын хүү 13 нэгж хувьд хүрч өссөн нь сүүлийн 5 жилийн хамгийн өндөр үзүүлэлт юм.

Хүү өндөр байгаа үед өндөр хүүтэй, урт хугацаатай бондод сайтар судалгаа, шинжилгээ хийсний үндсэн дээр хөрөнгө оруулалт хийх нь ашигтай.

Зах зээлийн жишиг хүү, хугацааны талаар мэдээлэлтэй байх нь харьцуулалт хийж, ухаалаг шийдвэр гаргахад туслана.

Бодлогын хүү 12 хувьд хүрч өссөнөөс хойш Биржийн Бус Зах Зээлд гарсан бондуудын хугацаанд харгалзах дундаж өгөөжийг доор харууллаа.

## БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН БОНДУУДЫН ӨГӨӨЖИЙН МУРУЙ




*Эх сурвалж: Голомт Капитал ҮЦК ХХК-ийн тооцооллоор*

Бондын өгөөжийн муруй нь зах зээлд гарч буй бондуудын хугацаа болон өгөөжийн хамаарлыг илтгэдэг.

# 2023 ОНД ГАРГАСАН ОНЦЛОХ БОНДУУД

2023 он гарснаар Голомт Капитал ҮЦК ХХК нь эдийн засгийн 7 салбарын 30 гаруй компаниудын үнэт цаасыг олон нийтэд санал болгож нийтдээ 300 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн.

**ГРАФИК: 2023 ОНД ГАРГАСАН ОНЦЛОХ БОНДУУД**




**СИМПЛ | ₮55 тэрбум**




**МАСТЕР | ₮25 тэрбум**




**ХАН АЛТАЙ | ₮45 тэрбум**




**ШУНХЛАЙ | ₮50 тэрбум**



**ЦАХИЛГААН СТАНЦ | $50 сая**



**ПРЕМИУМ | ₮15 тэрбум**

# ГОЛОМТ КАПИТАЛЫН САНАЛ БОЛГОЖ БУЙ БОНДУУД

## ТӨГРӨГИЙН БОНД

| Хугацаа | Хүү |
| --- | --- |
| 1 сар | **13.00%** |
| 3 сар | **14.00%** |
| 6 сар | **16.00%** |
| **Ам.доллартай уягдсан бонд** | |
| Компанийн бонд | **8.00%** |

## ГАДААД БОНД /ам.доллар/

| Бондын төрөл | Хүү |
| --- | --- |
| Монгол Улсын засгийн газрын бонд | **6.48%-7.31%** |
| Компанийн бонд | **10.47%-11.50%** |

*Тэмдэглэл: Хүүгийн түвшин 2024 оны 1 сарын байдлаар*

## БОНДЫН ЗАХИАЛГА ӨГӨХ

**(976) 8888-0272**
**(976) 8003-7272**
**(976) 8610-5050**

# БОНДЫН ЗАХ ЗЭЭЛД ХӨЛ ТАВЬЖ АМЖСАН УУ?



**Р. Дарханбаяр**
*Ахлах шинжээч, Хөрөнгө удирдлага, судалгааны газар*

## ДОЛЛАРАА ЯАХ ВЭ? | АМ.ДОЛЛАРЫН БОНД АВАХ УУ?

Та олон улсын зах зээлд арилжаалагдаж буй өндөр өгөөжтэй ам.долларын бондуудад хөрөнгө оруулснаар бондын хүү болон бондын үнийн өөрчлөлтөөс ашиг хүртэх боломжтой.

**АНУ-ЫН БОНДУУДЫН ӨГӨӨЖ 2007 ОНООС ХОЙШ ДЭЭД ТҮВШИНДЭЭ АРИЛЖААЛАГДАЖ БАЙНА. ҮҮНИЙГ ДАГАН АМ.ДОЛЛАРААР ИЛЭРХИЙЛЭГДЭХ МОНГОЛ УЛСААС ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛД ГАРГАСАН БОНДУУДЫН ӨГӨӨЖ Ч ӨНДӨР ТҮВШИНД БАЙНА. ИРЭХ ОНЫ СҮҮЛИЙН ХАГАСТ УЛС ОРНУУД БОДЛОГЫН ХҮҮГЭЭ БУУРУУЛСНААР БОНДУУДЫН ӨГӨӨЖ БУУРАХ МАГАДЛАЛТАЙ ТУЛ БАГЦЫН ТОДОРХОЙ ХЭСГЭЭ АМЖИЖ АМ.ДОЛЛАРЫН БОНДУУДАД БАЙРШУУЛАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.**

### АМ.ДОЛЛАРЫН СУУРЬ ӨГӨӨЖ /АНУ-ЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БОНДЫН ӨГӨӨЖ/




*Эх сурвалж: Tradingview*

# КОМПАНИЙН БОНДУУД

Монголиан Майнинг Корпораци (Энержи Ресурс) ХХК, Монголын Ипотекийн Корпораци ОССК-ууд олон улсын зах зээлд бонд гаргаад байна. Хөрөнгө оруулагчдын хувьд эдгээр бондуудад брокерийн компаниар дамжуулан хөрөнгө оруулах боломжтой.

# ММС ЭНЕРЖИ РЕСУРС КОМПАНИЙН БОНД

## ХҮЛЭЭЛТИЙГ ДАВСАН ШИНЭ БОНД

Тайлангийн үзүүлэлтүүдээс дурдвал, 2023 оны хагас жилд ММС нь 136.5 сая ам.долларын цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны эхний хагас жилийн нийт орлогоос 30.0 сая ам.доллараар илүү байна.

Тус компанийн нүүрсний борлуулалт эхний хагас жилийн байдлаар 4.9 тоннд хүрч өнгөрсөн оныхоос 5.4 дахин өсөж, EBITDA (хүү татвар элэгдлийн өмнөх ашиг) 258 сая ам.долларт хүрсэн байна.

Харин тус компанийн бондын нийт өр төлбөр 220 сая ам.доллараар хэмжигдэж байгаа нь төлбөрийн эрсдэл бага болохыг илтгэж байна.

### ММС БОНДЫН ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ӨГӨӨЖ




*Эх сурвалж: Thomson Reuters Eikon*

# МИК КОМПАНИЙН "БӨРТЭ" БОНД

## | ӨНДӨР ЭРЭЛТ

Монголын Ипотекийн Корпораци ОССК компанийн 2024 оны 2 сард хугацаа нь дуусах ам.долларын бондын ханш 643.61 ам.долларт хүрч унаснаар 2022 онд өгөөж нь жилийн 55.21 хувьд хүрч өссөн.

Харин одоо тус бондын өгөөж 13 хувь орчимд хэлбэлзэж байна.

МИК бондын зарцуулалт нь буцаах нөхцөлтэй зээлийн багцыг банкнуудаас худалдан авахад зориулагддаг бөгөөд бондын төлөлт дэхмэгц зээлийн багцуудаа арилжааны банкнуудад буцааж худалдах замаар төлбөрийн үүргээ биелүүлдэг.

Иймд хоёрдогч зах зээлд МИК компанийн гаргасан "Бөртэ" бондын эрэлт санхүүгийн байгууллагуудын дунд өндөр байна

### МIK БОНДЫН ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ ХАНШ /MIKX 8.85 08-FEB-2024/




*Эх сурвалж: Thomson Reuters Eikon*

# ЗАСГИЙН ГАЗРЫН АМ.ДОЛЛАРЫН БОНД

## | ЭРСДЭЛ БАГА, ӨГӨӨЖ ӨНДӨР

Аливаа улсын Засгийн газар нь банк болон компаниудаасаа өндөр зээлжих зэрэглэлтэй, найдвартай байдаг. Олон улсын зах зээлд гарсан Монгол Улсын Засгийн газрын нээлттэй бондуудын өгөөж 6.1-7.2 хувь байна.

Энэ нь ам.долларын хадгаламжийн хүүнээс даруй 1.5-2 дахин өндөр өгөөж юм.

### ХУРАЛДАЙ БОНДЫН ӨГӨӨЖ /MNGV 8.75 09-MAR-2024/




*Эх сурвалж: Thomson Reuters Eikon*

### ЗАСГИЙН ГАЗРЫН БОНДУУДЫН ӨГӨӨЖ

| № | Бондын нэр | Валют | Хүү | Өгөөж (2023-12-20) | Хэмжээ | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | МУЗГ (Хуралдай) | USD | 8.75% | 2.99% | $600,000,000 | 2024-03-09 |
| 2 | МУЗГ (Номад) | USD | 5.125% | 6.11% | $600,000,000 | 2026-04-07 |
| 3 | МУЗГ (Century) | USD | 3.5% | 6.63% | $500,000,000 | 2027-07-07 |
| 4 | МУЗГ (Хүннү) | USD | 8.65% | 6.95% | $650,000,000 | 2028-01-19 |
| 5 | МУЗГ (Century) | USD | 4.45% | 7.12% | $500,000,000 | 2031-07-07 |

*Эх сурвалж: Thomson Reuters Eikon*

**ИРЭХ ОНД ТӨСВИЙН ЗАРДЛЫН ҮНИЙН ӨСӨЛТӨД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨГ СААРУУЛАХ ЗОРИЛГООР МОНГОЛБАНКНААС МӨНГӨНИЙ ХАТУУ БОДЛОГОО ҮРГЭЛЖЛҮҮЛЭН БАРИХ ТӨЛӨВТЭЙ БАЙНА. ЭНЭ НЬ БОДЛОГЫН ХҮҮГ ОДООГИЙН ТҮВШИНД ӨНДӨР ХЭВЭЭР ХАДГАЛАН, БОНДЫН ӨГӨӨЖ ӨНДӨР БАЙХ ДОХИОГ ӨГЧ БАЙНА.**
**ИЙНХҮҮ ИРЭХ ОНД Ч БОНДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАД ТААТАЙ ЖИЛ ДАХИН ТОХИОЖ БАЙНА.**

# ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ 2023 ОНД



**Т.Азтүшиг**
*Ахлах шинжээч, Хөрөнгө удирдлага, судалгааны газар*

## ХУВЬЦААНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛЛОХ ИНДЕКСҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ

*Эх сурвалж: Investing.com /2023 оны 12 сарын 8 өдрийн ханшаар*




Томоохон улс орнуудын төв банкнаас хэрэгжүүлсэн мөнгөний бодлогын үр дүнд инфляцын түвшин буурсан нь хөрөнгө оруулагчдад цаашид хүү буурна гэсэн хүлээлтийг үүсгэв.

Мөнгөний урсгал найдвартай хөрөнгө оруулалтын хэрэгслүүд болох засгийн газрын болон өндөр зэрэглэлтэй компанийн бондуудаас өндөр хэлбэлзэлтэй хувьцааны зах зээл рүү шилжлээ.

## ХУВЬЦААНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ДНБ-ТЭЙ ХАРЬЦУУЛСНААР




*Тэмдэглэл: Ханшийг 2023 оны 12 сарын 8 өдрийн байдлаар тооцов.*

Энэ онд хөгжингүй орнуудын хувьцааны зах зээл сэргэснээр хувьцааны зах зээлийн нийт үнэлгээ ДНБ-ийн үзүүлэлттэйгээ харьцуулахад өндөр байна. Гэхдээ эдгээр орнуудаас Япон, Их Британи, БНХАУ зэрэг улсуудын хувьцааны зах зээл ДНБ-тэйгээ харьцуулахад багаар үнэлэгдэж байж болохуйц үзүүлэлттэй байгаа юм.

## ХУВЬЦААНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД




*Тэмдэглэл: Ханшийг 2023 оны 12 сарын 8 өдрийн байдлаар тооцов.*

Мөн эдгээр улс орнуудын үнэлгээний голлох харьцаа үзүүлэлтүүдээс харахад Япон, Канад, Их Британи зэрэг улсын хувьцааны зах зээл бусадтай нь харьцуулахад багаар үнэлэгдэж байна.

### ТАВААРЫН БҮТЭЭГДЭХҮҮНҮҮДИЙН ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТ

*Эх сурвалж: Investing.com /2023 оны 12 сарын 8 өдрийн ханшаар/*




2023 оны төгсгөлд Ойрх дорнодод дайны нөхцөл байдал даамжирснаас шалтгаалж алтны ханш бүх цаг үеийн түүхэн дээд ханшаа дахин нэг удаа тогтоолоо.

Мөн ирэх онд ам.долларын ханш сулрах хүлээлттэй байгаа учраас ам.доллараар илэрхийлэгдэж буй тавааруудын үнэ өсөхөд дэмжлэг болов.

### АНУ-ЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БОНДЫН ӨГӨӨЖ




*Эх сурвалж: Thomson Reuters Eikon*

Улс орнуудын инфляцын түвшнийг бууруулахын тулд хэрэгжүүлсэн мөнгөний хатуу бодлого санхүүжилтийн зардлыг давхар нэмэгдүүллээ.
Бодлогын хүү өссөнөөс шалтгаалж эрсдэлгүй өгөөжид тооцогддог АНУ-ын засгийн газрын

10 жилийн хугацаат бондын өгөөж 2008 оны санхүүгийн хямралын үеийн түвшинд буюу 4.93 хувьд хүрлээ.
Харин ирэх онд бодлогын хүү буурах хүлээлтээс шалтгаалж бондын өгөөж буурч байна.

# УНАЛТААС ӨСӨЛТ РҮҮ

## АНУ-ЫН ХУВЬЦААНЫ ЗАХ ЗЭЭЛ /2023 он/



**Г. Төгөлдөр /FRM/**
*Гадаад номинал данс хариуцсан брокер, Арилжааны газар*

Дэлхийн хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илтгэгч АНУ-ын хөрөнгийн зах зээлийн голлох индексүүд энэ онд өсөлттэй байв.

2022 онд хөрөнгийн зах зээлийг уналтад оруулсан гол хүчин зүйл болох инфляцын түвшин 2022 оны 6 сард сүүлийн 40 жилийн оргил цэг болох 9.1 хувьд хүрсэн бол 2023 оны 10 сарын байдлаар 3.2 хувьд хүрч буурлаа.

АНУ-ын төв банкнаас инфляцын түвшнийг 2 хувьд хүргэх зорилтын дагуу мөнгөний хатуу бодлогыг хэрэгжүүлснээр инфляцын түвшин аажмаар буурч байна.

Оны эхэнд инфляцын түвшин эрчтэй буурснаас шалтгаалж хөрөнгө оруулагчдын мөнгөний урсгал эргээд хувьцааны зах зээл рүү шилжлээ.

2021 оны 12 сарын 31-ний байдлаар АНУ-ын хувьцааны зах зээлийн нийт үнэлгээ 52.2 их наяд ам.долларт хүрч байсан бол 2022 онд улс орнуудын төв банкны бодлого, дайны нөлөөгөөр 40.5 их наяд ам.доллар болтлоо унажээ.

Харин 2023 оны 12 сарын 7-ны байдлаар АНУ-ын хувьцааны зах зээлийн нийт үнэлгээ 48.9 их наяд ам.доллар буюу оны эхнээс 20.7 хувиар өсжээ.

**2022 ОНД ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД ҮРГЭЛЖИЛСЭН ТОМООХОН УНАЛТЫН ДАРАА S&P 500 ИНДЕКС ОНЫ ЭХНЭЭС 18.95 ХУВИАР ӨССӨНӨӨР ХАНШИЙН ТРЕНД ТЕХНИК ТАЛААС ӨСӨЛТ РҮҮ ШИЛЖЛЭЭ.**

**ЭНЭ ХУГАЦААНД S&P 500 ИНДЕКСИЙН ДУНДАЖ ФОРВАРД ҮНЭ АШГИЙН ХАРЬЦАА 18.7, ДАНСНЫ ҮНИЙН ХАРЬЦАА 3.82 БУЮУ ТҮҮХЭН ДУНДЖААС ӨНДРӨӨР ҮНЭЛЭГДЭЖ ЭХЭЛСЭН БӨГӨӨД ИНДЕКСЭД БАГТАЖ БУЙ КОМПАНИУДЫН АШИГТ АЖИЛЛАГАА ХЭВИЙН БАЙНА.**

**ӨСӨЛТИЙН ТРЕНДИЙГ ДАГАЖ АРИЛЖААНД ОРОЛЦОХ УУ?**

| ИНДЕКАТОР | 3/24/2000 | 10/9/2007 | 2/19/2020 | 1/3/2022 | 11/30/2023 |
|---|---|---|---|---|---|
| Индекс | 1527 | 1565 | 3386 | 4797 | 4,568 |
| Үнэ ашигийн харьцаа (P/E fwd) | 25.2x | 15.1x | 19.2x | 21.4x | 18.7x |
| Ногдол ашигийн өгөөж | 1.4% | 1.9% | 1.9% | 1.3% | 1.6% |
| 10 жил хугацаат бонд өгөөж | 6.2% | 4.7% | 1.6% | 1.6% | 4.4% |




*Эх сурвалж: JPMorgan Asset Management*

## КОМПАНИУДЫН ТАЙЛАН ХЭВИЙН БАЙНА

2023 оны 3-р улирлын тайлангаар S&P 500 индексэд багтаж буй компаниудын дундаж цэвэр ашгийн өсөлт 4.8 хувь буюу 2022 оны 3 улирлаас хойш анх удаа эерэг үзүүлэлттэй гарлаа.

Тус тоон үзүүлэлтээс харахад компаниудын үйл ажиллагаа сайжирч эхэлж байгаа бөгөөд ирэх онд ашиг болон орлогын хүлээлт өндөр байна.

### S&P 500 ТАЙЛАНГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД (Y/Y)

*Эх сурвалж: Factset, Zacks*




2023 оны 3-р улирлын тайлангийн үзүүлэлтээр S&P 500 индексэд багтаж буй компаниудын 81.3 хувь нь цэвэр ашгийн үзүүлэлтээр шинжээчдийн хүлээлтийг эвдсэн тайлан танилцуулжээ. Энэ нь 2021 оны 2 улирлаас хойших хамгийн өндөр үзүүлэлт юм.

## S&P 500 КОМПАНИ ЦЭВЭР АШГИЙН ҮЗҮҮЛЭЛТ ШИНЖЭЭЧДИЙН ТААМАГЛАЛЫГ ДАВСАН ХУВЬ

*Эх сурвалж: Lipper Alpha Insight*




## ИНДЕКСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД ТҮҮХЭН ДУНДЖААС ӨНДӨР БАЙНА

S&P 500 индексийн үнэлгээ түүхэн харьцаа үзүүлэлтүүд

*Эх сурвалж: JPMorgan Asset Management*




| ИНДЕКАТОР | ТАЙЛБАР | СҮҮЛИЙН БАЙДЛААР | 25 ЖИЛ ДУНДАЖ | СТД. ХАЗ |
|---|---|---|---|---|
| P/E | Форвард үнэ/ашиг | 18.73x | 16.75x | 0.60 |
| CAPE | Шиллер үнэ/ашиг | 31.05x | 27.72x | 0.53 |
| Div. Yield | Ногдол ашигийн өгөөж | 1.60% | 1.98% | 1.12 |
| P/B | Үнэ/ дансны үнэ | 3.82x | 3.1x | 0.89 |
| P/CF | Үнэ/ мөнгөн урсгал | 14.26x | 11.28x | 1.35 |

S&P 500 индексийн үнэлгээг түүхэн үзүүлэлттэй нь харьцуулахад дунджаар үнэлэгдэж байна.

2023 оны 11 сарын 30-ны байдлаар S&P 500 индексийн үнэ ашгийн харьцаа 18.73 үржүүлэгчтэй буюу сүүлийн 5 жилийн дундаж (18.8) үзүүлэлтээс багаар үнэлэгдэж байгаа бол сүүлийн 10 жилийн дундаж (17.6) үзүүлэлтээс өндрөөр үнэлэгдэж байна.

# ТОХИРОМЖТОЙ БҮС

## БНХАУ ХУВЬЦААНЫ ЗАХ ЗЭЭЛ /2023 он/

БНХАУ 2022 оны 10 сард цар тахлын хөл хориогоо суллаж, эдийн засгаа нээснээр оны эхний хагаст дотоодын нийт бүтээгдэхүүн /ДНБ/ шинжээчдийн хүлээлтийн дагуу буюу 5.5 хувиар тэллээ.

БНХАУ-ын бодлого тодорхойлогч байгууллагуудаас эхний хагас жилд үл хөдлөх хөрөнгийн салбарын өрийн бүтцийг сайжруулах зорилготой арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн ч үр дүнд хүрсэнгүй.

**БНХАУ-ЫН SHANGHAI COMPOSITE ИНДЕКСИЙН ДУНДАЖ ҮНЭ АШГИЙН ХАРЬЦАА СҮҮЛИЙН 5,10 БОЛОН 25 ЖИЛИЙН ДУНДЖААС БАГААР ҮНЭЛЭГДЭЖ ЭХЭЛЛЭЭ. ХАРИН ХОНГКОНГИЙН HANG SENG ИНДЕКСИЙН ХУВЬД МӨН АДИЛ ҮНЭЛГЭЭНИЙ ҮНЭ АШГИЙН ХАРЬЦАА СҮҮЛИЙН 5,10 БОЛОН 25 ЖИЛИЙН ДУНДЖААС БАГААР ҮНЭЛЭГДЭЖ БАЙНА. БНХАУ ЭДИЙН ЗАСГАА НЭЭСНЭЭР ИНДЕКСҮҮД ӨССӨН Ч ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН САЛБАРЫН ХЯМРАЛААС ШАЛТГААЛАН ДИЙЛЭНХ ХУВЬЦААНУУД ХУДАЛДАН АВАХАД “ТОХИРОМЖТОЙ” БҮС ДЭЭР ЭРГЭН ИРЛЭЭ.**

2023 оны 8 сарын 17-нд өдөр дэлхийн үл хөдлөх хөрөнгийн салбарын хамгийн том компани болох Evergrande Group дампуурлаа албан ёсоор зарлаж, АНУ-ын дампуурлын тухайн хуулийн 15-р тоггоолд файлаа хүргүүллээ.

Тус үйл явдлын дараа БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарт 2-т эрэмблэгддэг Country Garden Holdings компани бондын дампуурлаа зарлалаа.

2023 оны эхний улиралд эдийн засаг нээгдсэнээс шалтгаалсан индексүүдийн өсөлт, үл хөдлөх хөрөнгийн салбарын хямралын улмаас хөрөнгө оруулагчдын итгэл буурч хөрөнгийн зах зээлийн голлох индексүүд уналтад орлоо.

### SHANGHAI COMPOSITE INDEX ХАНШИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ҮНЭЛГЭЭ

*Эх сурвалж: MacroMicro, Ceicdata*




Дээр дурдсан хүчин зүйлсээс шалтгаалж БНХАУ-ын Shanghai Composite Index 2023 оны 12 сарын 8 өдрийн байдлаар оны эхнээс 3.63 хувийн уналттай хаагдлаа.

## SHANGHAI COMPOSITE INDEX-ИЙН ҮНЭЛГЭЭ, ТҮҮХЭН ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД

*Эх сурвалж: MacroMicro, Ceicdata*




| ИНДЕКАТОР | P/E ҮЗҮҮЛЭЛТ | ЗӨРҮҮ (11-р сартай харьцуулбал) |
|---|---|---|
| 25 жилийн дундаж | 23.72x | -11.88x |
| 10 жилийн дундаж | 15.41x | -3.57x |
| 5 жилийн дундаж | 14.73x | -2.89 |

Shanghai Composite Index -ийн үнэлгээг түүхэн үзүүлэлттэй нь харьцуулахад багаар үнэлэгдэж байна.
2023 оны 12 сарын 10 өдрийн байдлаар Shanghai Composite Index -ийн үнэ ашгийн харьцаа 11.83 үржүүлэгчтэй буюу сүүлийн 25 жилийн дундаж болох 23.72 үржүүлэгчээс багаар үнэлэгдэж байна.

## HANG SENG INDEX ХАНШИЙН ҮЗҮҮЛЭЛТ ҮНЭЛГЭЭ

*Эх сурвалж: Hang Seng Bank*




Харин ХонгКонгийн Hang Seng Index-ийн хувьд оны эхнээс 2023 оны 12 сарын 8 өдрийн байдлаар оны эхнээс 16.47 хувиар унасан байна.

Тодруулбал, Hang Seng Tech Index 12.4 хувиар, Hang Seng Finance Index 13.9 хувиар, Hang Seng Utilities Index 18.6 хувиар, Hang Seng Properties Index 36.2 хувиар тус тус унажээ.

## HANG SENG INDEX ҮНЭЛГЭЭ, ТҮҮХЭН ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД

*Эх сурвалж: Hang Seng Bank*




| ИНДЕКАТОР | P/E ҮЗҮҮЛЭЛТ | ЗӨРҮҮ (11-р сартай харьцуулбал) |
|---|---|---|
| 25 жилийн дундаж | 13.84x | -3.57x |
| 10 жилийн дундаж | 11.88x | -1.61x |
| 5 жилийн дундаж | 12.30x | -2.03x |

Hang Seng Index -ийн үнэлгээг түүхэн үзүүлэлттэй нь харьцуулахад багаар үнэлэгдэж байна.

2023 оны 12 сарын 06 өдрийн байдлаар Hang Seng Index -ийн үнэ ашгийн харьцаа 10.27 үржүүлэгчтэй буюу сүүлийн 25 жилийн дундаж болох 13.84, 10 жилийн дундаж болох 11.88, 5 жилийн дундаж болох 12.3 үржүүлэгчдээс багаар үнэлэгдэж байна.

Ингэхдээ сүүлийн 25 жилийн стандарт хазайлтын бүс дээр үнэлгээний түвшин тогтож байна.

# САНГИЙН МЕНЕЖЕРҮҮД ЮУНД ХӨРӨНГӨ ОРУУЛЖ БАЙНА ВЭ?

## ДЭЛХИЙН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ /2024 он/



**Т.Азтүшиг**
*Ахлах шинжээч, Хөрөнгө удирдлага, судалгааны газар*

BofA Global Fund Manager Survey буюу нийт 552 тэрбум ам.долларын үнэлгээ бүхий санг удирддаг дэлхийн 225 сангийн менежерүүдийн хамрагддаг судалгаагаар ирэх онд хамгийн оновчтой хөрөнгө оруулалтаар засгийн газрын бондуудыг нэрлэлээ.

**ИРЭХ ОНД ХАМГИЙН ӨНДӨР ӨГӨӨЖТЭЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БҮТЭЭГДЭХҮҮН БОЛ БОНДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БАЙХ ТӨЛӨВТЭЙ БАЙНА.**
**МӨН ДИЙЛЭНХ САНГУУД ЯПОН РУУ ЧИГЛЭСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАА НЭМЖ БАЙГАА БОЛ САНГУУДЫН БЭЛЭН МӨНГӨНИЙ ХЭМЖЭЭ 4.7 ХУВЬ БУЮУ "ХУДАЛДАН АВАХ" СИГНАЛ ДУУСАЖ БАЙГААГ ИЛТГЭЖ БАЙНА.**

### ИРЭХ ОНД ХАМГИЙН ӨНДӨР ҮЗҮҮЛЭЛТТЭЙ БАЙХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БҮТЭЭГДЭХҮҮН ЮУ ВЭ?

*Эх сурвалж: Hang Seng Bank*




Нийт сангийн менежерүүдийн 94 хувь нь ирэх онд бонд, хувьцаа, таваарын хөрөнгө оруулалт нь мөнгөний захын үзүүлэлтийг эвдэнэ гэсэн хүлээлттэй байна.

Үүнээс 54 хувь нь бондын зах зээл хамгийн өндөр өгөөжтэй байна гэсэн хүлээлттэй байгаа юм.

## САНГУУДЫН МӨНГӨ ХААШАА ЧИГЛЭЖ БАЙНА ВЭ?

*Эх сурвалж: BofA Global Fund Manager Survey*




2023 оны 11 сарын сангуудын хөрөнгө оруулалтын эзэмшлийг сүүлийн 20 жилтэй нь харьцуулбал бонд, харилцаа холбоо, эрүүл мэнд, Япон болон АНУ руу чиглэсэн хөрөнгө оруулалт нэмэгдсэн бол эсрэгээрээ Евро бүс, Их Британи, аж үйлдвэр, үндсэн материал, үл хөдлөх рүү чиглэсэн хөрөнгө оруулалт буурчээ.

## САНГУУДАД БЭЛЭН МӨНГӨ ХАНГАЛТТАЙ БАЙНА УУ?

*Эх сурвалж: BofA Global Fund Manager Survey*




2023 оны 11 сарын байдлаар сангуудын бэлэн мөнгөний хэмжээ 10 сараас 55 суурь нэгжээр буюу 5.3 хувиас 4.7 хувь болж буурчээ.

Үүнд, компаниудын 3 улирлын тайлан хүлээлтээс харьцангуй сайн гарсан нь голлон нөлөөлсөн ч бэлэн мөнгөний хэмжээ хурдацтай буурч байгаа нь хөрөнгийн зах зээлд шинээр мөнгө орох орон зай багасаж байгааг илтгэж байна.

БААВГАЙ

# БУХ ДИЙЛЛЭЭ



# БААВГАЙГ БУХ ДИЙЛЛЭЭ

## АНУ-ЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ | 2024 он



**Р. Дарханбаяр**
*Ахлах шинжээч, Хөрөнгө удирдлага, судалгааны газар*

АНУ-ын хөрөнгийн зах зээлийн уналтыг өдөөж, өсөлтийг хязгаарлаж байсан гол 2 хүчин зүйл нь бодлогын хүү болон инфляцын түвшин юм.

**ХЯМРАЛЫН ДАРААХ 1 ЖИЛИЙН ХУГАЦААНД S&P 500 ИНДЕКС ДУНДЖААР 43 ХУВИАР СЭРГЭДЭГ БОЛ 2022 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН УДААШРАЛЫН ЁРООЛ ЦЭГ БОЛОХ 2022 ОНЫ 10 САРЫН 21-НИЙ ХАНШААС 2023 ОНЫ 11 САРЫН 30-НЫ ХООРОНД S&P 500 ИНДЕКС 31 ХУВИАР ӨСЖЭЭ.**

### НИЙЛҮҮЛЭЛТИЙН ИНФЛЯЦААС ЭРЭЛТИЙН ИНФЛЯЦ РУУ

2023 оны сүүлийн хагас жилд хэрэглээний үнийн индекс 3.0-3.2 хувь дээр хадгалагдах хүлээлттэй байгаа бол 2024 онд 1.2 хувиар буурч 2.0 хувьд хүрэх төлөвтэй байгаа юм.

АНУ-ын инфляцын задаргааг харвал 2023 оны 3 дугаар сарыг хүртэл гадаад хүчин зүйлээс хамааралтай буюу эрчим хүчний үнэ, хоол хүнсний үнийн өсөлт (нийлүүлэлтийн инфляц) инфляцыг өдөөж байсан бол эдгээрийн нөлөө 11-р сарын байдлаар арилсан байна.

Харин 9 сараас хойш инфляцыг орон байрны үнийн өсөлт, үйлчилгээний үнийн өсөлт, бусад бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт бүрдүүлж байна.

Эдгээр нь бодлогын хүүгээр зохицуулж болохуйц буюу эрэлтийн шинж чанартай инфляц тул бодлогын хүүг богино хугацаанд өндөр хэвээр хадгалснаар инфляц буурах хүлээлттэй байна.

# БОДЛОГЫН ХҮҮ БУУРАХ ХҮЛЭЭЛТТЭЙ БАЙНА

2022 онд АНУ-ын хөрөнгийн зах зээлийн голлох индексүүдийг унагахад голлон нөлөөлсөн мөнгөний хатуу бодлогын эрч 2023 онд үргэлжилж, 2024 оны 5-р сараас эхлэн сулрах төлөвтэй байна.

Бодлогын хүү 2022 онд 0.25 хувиас 4.5 хувь болтлоо огцом өссөн бол 2023 оны эхний 11 сарын байдлаар 5.5 хувь буюу 1 хувиар нэмэгджээ.

## АНУ-ЫН ИНФЛЯЦЫН ТҮВШИН БОЛОН БОДЛОГЫН ХҮҮГИЙН ТӨСӨӨЛӨЛ

*Эх сурвалж: US Federal Reserve, Federal Open Market Committee, Economic Projection, 13 June 2023*






# 2024 ОНД БИДНИЙГ ЮУ ХҮЛЭЭЖ БАЙНА ВЭ?

## ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ЖИЛД ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ ӨСДӨГ



**Р. Дарханбаяр**
*Ахлах шинжээч, Хөрөнгө удирдлага, судалгааны газар*

Хөрөнгийн зах зээлийн хөдөлгөөн нь ерөнхийлөгчийн сонгуулийн мөчлөгтэй корреляцитай байдаг.

Тухайлбал, сонгуулийн өмнөх жил болон сонгуулийн жилүүдэд S&P 500 индексийн өсөх магадлал өндөр байна.

**2023 ОНЫ 11 САРЫН GIOBAI FUNDS SURVEY-ИЙН МЭДЭЭЛЛЭЭС ХАРВАЛ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГУУДЫН 76% НЬ ХНС-ИЙН ХАТУУ БОДЛОГО ДУУСГАВАР БОЛНО ГЭСЭН ХҮЛЭЭЛТТЭЙ БАЙГАА БОЛ 38% НЬ СҮҮЛИЙН 3 САРД АНУ-ЫН ТОМООХОН ТЕХНОЛОГИЙН КОМПАНИУДЫН ХУВЬЦААНД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙСЭН, 22% НЬ ХЯТАДЫН ХУВЬЦААНУУДАД БОГИНО АРИЛЖААНД ОРСОН БУЮУ ЗАРСАН БАЙНА.**

### СОНГУУЛИЙН МӨЧЛӨГ БА УНАЛТ ӨСӨЛТИЙН ДАВТАМЖ

*Эх сурвалж: CMTA*

| | Сонгуулийн жил | Сонгуулийн дараах жил | Сонгуулийн дунд жил | Сонгуулийн өмнөх жил |
|---|---|---|---|---|
| Хөрөнгийн зах өссөн тоо | 13 | 9 | 11 | 15 |
| Хөрөнгийн зах унасан тоо | 3 | 7 | 6 | 2 |

### СОНГУУЛИЙН МӨЧЛӨГ БА S&P500 ИНДЕКСИЙН ӨГӨӨЖ

*Эх сурвалж: CMTA*



## АНУ-ЫН КОМПАНИУДЫН ЦЭВЭР АШИГ ӨСӨХ ХҮЛЭЭЛТТЭЙ БАЙНА

2023 оны 12 сарын 1 өдрийн байдлаар S&P 500 индексэд багтдаг компаниудын 98% нь 3 улирлын тайлангаа танилцуулсан ба тэдгээрийн 82% нь ашгийн хүлээлтээ даваад байна.

### S&P500 АШГИЙН ХҮЛЭЭЛТИЙН ДАВАЛТЫН %

*Эх сурвалж: Earnings Factset*




Харин 2024 онд АНУ-ын S&P 500 индексэд багтдаг компаниудын цэвэр ашгийн өсөлт 17.3% байх хүлээлттэй байна.

## ЦЭВЭР АШГИЙН ӨСӨЛТӨД ДАРААХ ХҮЧИН ЗҮЙЛС НӨЛӨӨЛӨХӨӨР ТУСГАЖЭЭ:

- ИНФЛЯЦ БУУРНА — Компаниудын түүхий эд материалын зардал буурна
- БОДЛОГЫН ХҮҮ БУУРНА — Компаниудын санхүүжилтийн зардал буурна
- АМ.ДОЛЛАРЫН ХАНШ СУЛАРНА — Компаниудын экспортын орлого нэмэгдэнэ

# ӨСӨЛТ ЦААШИД ҮРГЭЛЖЛЭХ ҮҮ?



**Р. Дарханбаяр**
*Ахлах шинжээч, Хөрөнгө удирдлага, судалгааны газар*

Статистикаас үзэхэд S&P 500 индексийн дундаж өсөлт тухайн хямралын ёроолын цэгээс дунджаар 43 хувиар өсөж, индекс өсөлтийн тренд рүү шилжсэн тохиолдолд өсөлтийн эрчээ хадгалдаг байна.

Томоохон хямралуудын дараах сэргэлтүүдээс дурдвал 2008 оны санхүүгийн хямралын дараа S&P 500 индекс жилийн дотор 69 хувиар өссөн бол 2020 онд тохиосон Covid 19 цар тахлын дараа 78 хувиар өсжээ.

**Тэгвэл оны эхний хагаст тохиосон энэхүү өсөлт цаашид хэр хугацаанд үргэлжлэх вэ?**

График 12-д дурдсаны дагуу баавгай зах зээлээс бух зах зээл рүү шилжсэн мөчөөс эхлэн бух зах зээлийн үргэлжлэх дундаж хугацаа 5.9 жил байна.

**2023 ОНЫ 9-11 САРЫН ХООРОНД АНУ-ЫН ETF САНГУУДАД ОРЖ БУЙ МӨНГӨНИЙ УРСГАЛ ОГЦОМ НЭМЭГДСЭН БӨГӨӨД 3961 САНД НИЙТ 202.0 ТЭРБУМ АМ.ДОЛЛАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН УРСГАЛ ХИЙГДСЭН БАЙНА. ХАРИН ЕВРО БҮС БОЛОН ЯПОНООС БУСАД АЗИЙН ОРНУУДЫН САНГУУДАД ОРЖ БУЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН УРСГАЛ ТАТАРСАН БАЙНА.**

## ӨСӨЛТ БОЛОН УНАЛТЫН ЗАХ ЗЭЭЛИЙН СТАТИСТИК




*Эх сурвалж: The Vanguard Group*

The Vanguard Group-ийн тооцооллоор сүүлийн 75 жилийн 86.2 хувьд нь буюу 64.7 жилд бух зах зээл үргэлжилжээ.

Харин энэ хугацаанд ердөө 13.8 хувьд нь буюу 10.3 жилд баавгай зах зээл үргэлжилсэн байна.

Бух зах зээл дунджаар 5.9 жил үргэлжилдэг бол баавгай зах зээл 1.1 жилийн дундаж наслалттай байжээ.

## ОЛОН УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНКНУУДЫН ТААМАГЛАЛ

### S&P 500 ИНДЕКСИЙН ХАНШИЙН ТААМАГЛАЛ

*Эх сурвалж: Хөрөнгө оруулалтын банкнуудын албан ёсны мэдэгдэл*

| Компанийн нэр | 2024 оны таамаглал | 2023.12.01-ний ханштай харьцуулсан өөрчлөлт |
|---|---|---|
| Yardeni Research | 5400 | 17.5% |
| Oppenheimer Asset Management | 5200 | 13.1% |
| Fundstrat Global Advisors | 5200 | 13.1% |
| Citi | 5100 | 10.9% |
| Deutsche Bank | 5100 | 10.9% |
| BMO Capital Markets | 5100 | 10.9% |
| RBC Capital Markets | 5000 | 8.8% |
| Bank of America | 5000 | 8.8% |
| Barclays | 4800 | 4.4% |
| Goldman Sachs | 4700 | 2.2% |
| UBS Global Wealth Management | 4700 | 2.2% |
| Wells Fargo Securities | 4625 | 0.6% |
| Morgan Stanley | 4500 | -2.1% |
| JPMorgan | 4200 | -8.6% |
| **Дундаж** | **4902** | **6.6%** |
| **Медиан** | **5000** | **8.8%** |

2023 оны 12 сарын 1-ний байдлаар АНУ-ын S&P 500 индекс 4,599 нэгжээр илэрхийлэгдэж байна. Харин олон улсын хөрөнгө оруулалтын банкнуудын үзэж буйгаар S&P 500 индекс 2024 онд дунджаар 6.6 хувиар өсөх бол хамгийн өндөр таамаглалаар 17.5 хувиар өсөх төлөвтэй байна.

# БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛ



**Р. Дарханбаяр**
*Ахлах шинжээч, Хөрөнгө удирдлага, судалгааны газар*

## МАКРО ЭДИЙН ЗАСАГ ТАЛААС ХАРВАЛ

- АНУ-ын ДНБ сүүлийн улиралд 5.2% өсөлттэй байгаа ч GDI /gross domestic income/ буюу нийт бодит орлого -0.13% бууралттай байна.

- АНУ-д хувь хүмүүсийн орлогоосоо хадгаламж үүсгэж буй харьцаа 4.6%-д хүрч буурсан.

1960 оноос хойш энэхүү үзүүлэлт дунджаар 8.6% байсан. Иймд сүүлийн 2 жилд хадгаламж өсөөгүй бөгөөд жижиг хөрөнгө оруулагчид төсөөлж байсан шиг их хэмжээний мөнгөний хадгаламжаа цуцалж хөрөнгийн зах зээлд цутгаж чадахгүй болов уу гэсэн таамаг байгаа юм.

- Бодлогын хүүг өндөр хэмжээгээр өсгөсний дараа буюу хүүгээ бууруулах үетэй давхцан эдийн засгийн хямралууд тохиолддог. Хоёр улирал дараалан эдийн засгийн өсөлт сөрөг гарахыг эдийн засгийн хямрал гэж тодорхойлно.

### ХНС-ЫН БОДЛОГЫН ХҮҮ БА ХЯМРАЛЫН МӨЧЛӨГИЙН ДАВХЦАЛ

*Эх сурвалж: Marketwatch*



## ГЕОПОЛИТИКИЙН ЭРСДЭЛ ТАЛААС ХАРВАЛ

Blackrock хөрөнгө оруулалтын сангийн судалгаагаар дэлхийн геополитикийн эрсдэлийн индекс 2022 оны 3 сард 1 нэгж буюу дээд түвшиндээ ирсэн ба 2023 оны 12 сард өсөж 0.4 нэгжид хүрээд байна.

Хөрөнгө оруулалтад нөлөөлөхүйц хамгийн гол эрсдэлд, АНУ болон БНХАУ-ын стратегийн тэмцэл, технологийн ширүүн өрсөлдөөн ба хараат бус байдал, томоохон кибер халдлагууд орж байна.

Хамгийн том эрсдэл нь АНУ болон БНХАУ хоорондын стратегийн тэмцэл юм. Тодруулбал, АНУ-ын зүгээс цэргийн болон эдийн засгийн тусламжийг Тайванд үзүүлсээр байгаа бол Хятадын зүгээс Тайваны арлуудад дарамт үзүүлэхэд бэлэн байна.

Гэхдээ цэргийн үйл ажиллагаа ойрын хугацаанд гарахгүй гэж төсөөлж байгаа ч эрсдэл улам бүр нэмэгдсээр байна. Тиймээс 2024 оны 1 сард болох Тайваны Ерөнхийлөгчийн сонгууль олны анхаарлын төвд байна.

## ГЕОПОЛИТИКИЙН ЭРСДЭЛ БА ХҮЛЭЭГДЭЖ БУЙ МАГАДЛАЛ

*Эх сурвалж: EIU, World Economic Forum, The Economist Group, IMF, World Bank*



# S&P 500 ИНДЕКС ТЕХНИК ШИНЖИЛГЭЭ



**А.Билгүүн**
*Техник шинжээч, Хөрөнгө удирдлага, судалгааны газар*




2020-2021 оны өсөлтийн том давлагааны 50 хувиас буюу талаас нь хүчтэй өсөлтийн импульс авсан ба энэ нь дахин өмнөх оройн цэг рүү очих боломжтойг илэрхийлж байна.

12 сард богино хугацааны өсөлтийн трендийн higher high-ийг дээш давсан нь дунд хугацааны өсөлтийн трендэд шилжсэнийг илтгэж байна.

Тиймээс АНУ-ын хөрөнгийн зах зээл ирэх оны 4-5 дугаар сар хүртэл өсөлтийн чиг хандлагаа тогтвортой хадгалах бөгөөд бодлогын хүүг бууруулахтай зэрэгцэн завсрын хөдөлгөөн орох дүр зураг ажиглагдаж байна.

# ХЯТАДЫГ ЧИГЛЭСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

## | БНХАУ-ЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ | 2024 ОН



**Т.Азтүшиг**
*Ахлах шинжээч, Хөрөнгө удирдлага, судалгааны газар*

БНХАУ-аас 2022 оны төгсгөлд цар тахлын улмаас тогтоосон хөл хориог цуцалж эдийн засгаа нээснээр 2023 оны эхний хагас жилд эдийн засгийн өсөлт нь 5.5 хувь буюу хүлээлтийн дагуу гарсан.

Олон улсын шинжээчид БНХАУ-ын эдийн засгаа нээснээс үүдэлтэй нөлөөлөл арилж байна гэж дүгнэж байна.

Тиймээс 2023 оны 2 хагас жилд эдийн засгийн өсөлтийг хадгалж, зорилтот 5 хувьд хүргэхийн тулд засгийн газраас нэмэлт арга хэмжээг зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Учир нь цар тахлын хөл хориог цуцалсан шийдвэрийн дараах эдийн засагт үзүүлэх нөлөө суларч байгаагаас шалтгаалж, хөрөнгө оруулагчдын Хятадын зах зээлд итгэх итгэл буурсан юм.

**ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ 2023 ОНЫ 2 ХАГАС ЖИЛД ХАДГАЛАХ ҮҮДНЭЭС БНХАУ-ЫН УЛС ТӨРИЙН ТОВЧООНЫ 7 САРД БОЛСОН УУЛЗАЛТААР ЭДИЙН ЗАСГИЙГ ДЭМЖИХ ЦОГЦ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР БОЛЛОО.**

2023 оны 12 сарын 8-ны ханшаар Шанхайн хөрөнгийн биржийн Shanghai Composite Index оны эхнээс 3.68 хувийн уналттай байгаа бол Шенжений хөрөнгийн биржийн SZSE Component Index оны эхнээс 13.17 хувийн уналттай, Хонг Конгийн Hangseng Index 5.7 хувийн уналттай байна.

### БНХАУ ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

*Эх сурвалж: БНХАУ-ын статистикийн газар, Төрийн зөвлөлийн албан ёсны мэдэгдэл*



**БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙН ТӨСӨӨЛӨЛ**

*Эх сурвалж: Байгууллагуудын албан ёсны мэдэгдэл*

| Төсөөлөл гаргасан байгууллагууд | Таамаглал |
|---|---|
| Nomura | 5.10% |
| Bank of America | 5.10% |
| Morgan Stanley | 5.00% |
| Moody's | 5.10% |
| S&P Global | 5.20% |
| Fitch | 5.60% |
| Reuters Poll | 5.50% |
| IMF | 5.00% |
| World Bank | 5.60% |

# БНХАУ-ЫН УЛС ТӨРИЙН ТОВЧООНЫ ХУРАЛ

Эдийн засгийн өсөлтийг 2023 оны 2-р хагас жилд хадгалах үүднээс БНХАУ-ын Улс төрийн товчооны 7 сард болсон хурлаар сүүлийн хагас жилд эдийн засгийг дэмжих цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр болсон.



**ЭДИЙН ЗАСГИЙГ ДЭМЖИХ ЦОГЦ ХӨТӨЛБӨРИЙН ГОЛ БОДЛОГО**

- **Дэд бүтцэд оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх**

(засгийн газрын нэмэлт үнэт цаас, томоохон хөрөнгө оруулалт)

- **Мөнгөний зөөлөн бодлого**

(бодлогын хүүг бууруулах, жижиг дунд болон ногоон эдийн засгийг дэмжих)

- **Зарцуулалтыг нэмэгдүүлэх**

(автомашин, электрон бараа, гэр ахуйн бүтээгдэхүүнүүд ... зэрэгт төрийн дэмжлэг татаас олгох, бага орлоготой өрхүүдийн орлогыг нэмэгдүүлж, нийгмийн даатгалын бодлогоор дэмжих)

# МӨНГӨНИЙ ЗӨӨЛӨН БОДЛОГО

БНХАУ-ын Ардын банк оны эхнээс зээлийн жишиг хүү /цаашид бодлогын хүү гэх/ бодлогын хүүгээ 2 удаа буурууллаа.

Тодруулбал, 2023 оны 6 сарын 20-нд бодлогын хүүг 0.1 хувиар бууруулсан бол 2023 оны 8 сарын 21-нд 0.1 хувиар бууруулжээ.

Гэвч БНХАУ-ын инфляцын түвшин 2023 оны 11 сарын байдлаар -0.5 хувьд хүрч эдийн засагт дефляци үүсээд байна.

Инфляцын түвшин асар бага байгаа нь төв банканд бодлогын хүүг бууруулж, эдийн засагт мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх томоохон хөшүүрэг болж байна.

Тус нөхцөл байдлаас шалтгаалан цаашид эдийн засагт мөнгөний нийлүүлэлт, хөрөнгийн зах зээл рүү орох мөнгөний урсгал нэмэгдэх таатай нөхцөл бүрдлээ.

## БНХАУ-ЫН ЗЭЭЛИЙН ЖИШИГ ХҮҮ

*Эх сурвалж: БНХАУ-ын статистикийн газар*




## БНХАУ-ЫН ИНФЛЯЦЫН ТҮВШИН

*Эх сурвалж: БНХАУ-ын статистикийн газар*



## САНГУУД ХЯТАДЫН ЗАХ ЗЭЭЛЭЭС ГАРЛАА

Дийлэнх сангууд БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын хямрал, эдийн засгийн удаашрал, геополитикийн эрсдэл зэрэг хүчин зүйлсээс шалтгаалж тус улсын зах зээлээс гарлаа.

## САНГУУДЫН ЭЗЭМШЛИЙН ӨӨРЧЛӨЛТ

/БНХАУ 5 ЖИЛИЙН ӨМНӨХ ЭЗЭМШИЛТЭЙ ХАРЬЦУУЛСНААР/

*Эх сурвалж: Goldman Sachs, EPFR*




Графикт харуулснаар БНХАУ-ын зах зээлээс дэлхийн томоохон сангууд түүхэн үзүүлэлтүүдээсээ харьцангуй хурдацтай гарчээ.
Энэхүү үзүүлэлт нь хөрөнгө оруулагчид “Sentiment” буюу хэт сөрөг байгааг илтгэж байгаа бөгөөд эдийн засгийн чухал тоо эсвэл эерэг мэдээлэл гарвал тус зах зээл рүү мөнгөний урсгал буцаад орох дохиог өгч байна.

# ХЯТАД КОМПАНИУДЫН АШИГТ АЖИЛЛАГАА СЭРГЭХ ҮҮ?

### ФОРВАРД 12 САРЫН НЭГЖ ХУВЬЦААНД НОГДОХ ЦЭВЭР АШГИЙН ШИНЖЭЭЧДИЙН ХҮЛЭЭЛТ

*Эх сурвалж: Bloomberg, 2023-11-30*

Bloomberg-ийн шинжээчдийн үзэж байгаагаар БНХАУ-ын MSCI China Index болон CSI 300 индексэд багтаж буй компаниудын форвард 12 сарын нэгж хувьцаанд ногдох цэвэр ашгийн үзүүлэлт өндөр гарах хүлээлттэй байна.




Шинжээчдийн үзэж байгаагаар БНХАУ-ын төрийн зүгээс хэрэгжүүлж буй бодлого нь ирэх онд аж ахуйн нэгж байгууллагуудад эерэг нөлөө үзүүлнэ.

Мөн MSCI China Index болон CSI 300 индекс 11 сарын 30 өдрийн байдлаар үнэ ашгийн харьцаа харгалзан 9.3 болон 10.5 буюу сүүлийн 5 жилийн дунджаас 16-22 хувиар багаар үнэлэгдэж байна.

### ХЯТАД КОМПАНИУДЫН ЦЭВЭР АШГИЙН ӨСӨЛТИЙН ХҮЛЭЭЛТ

*Эх сурвалж: LSEG data*




London Stock Exchange Group-ийн БНХАУ-ын 500 сая ам.доллараас дээш зах зээлийн үнэлгээтэй 1,721 компаниудын дунд явуулсан судалгаагаар компаниуд өөрсдийн ирэх оны ашгийн хүлээлтээ өндрөөр төсөөлж байна.

Тодруулбал, судалгаанд хамрагдсан 1721 компаниудын цэвэр ашиг ирэх онд дунджаар 16 хувь буюу 2017 оноос хойших хамгийн өндөр өсөлтийг үзүүлэх хүлээлттэй байгаа юм байна.

BNP Paribas Asset Management-ийн хөрөнгө оруулалтын менежер Minyue Liu-ийн мэдэгдсэнээр, үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт, эдийн засгийн удаашралын эсрэг хэрэгжүүлж буй Хятадын засгийн газрын бодлого ирэх онд бизнес аж ахуйн нэгжүүдэд эерэгээр нөлөөлөх хүлээлттэй байна.

# ОНЦЛОХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

## БОНДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

**BOFA GLOBAL FUND MANAGER SURVEY БУЮУ НИЙТДЭЭ 552 ТЭРБУМ АМ.ДОЛЛАРЫН ҮНЭЛГЭЭ БҮХИЙ САН УДИРДДАГ ДЭЛХИЙН 225 САНГИЙН МЕНЕЖЕРҮҮДИЙН ХАМРАГДДАГ СУДАЛГААГААР ИРЭХ ОНД ХАМГИЙН ОНОВЧТОЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ЗАСГИЙН ГАЗРЫН БОНДУУДЫГ НЭРЛЭЛЭЭ.**

**НИЙТ САНГИЙН МЕНЕЖЕРҮҮДИЙН 94 ХУВЬ НЬ ИРЭХ ОНД БОНД, ХУВЬЦАА БОЛОН ТАВААРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ НЬ МӨНГӨНИЙ ЗАХЫН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ЭВДЭНЭ ГЭСЭН ХҮЛЭЭЛТТЭЙ БАЙНА.**

**ҮҮНЭЭС 54 ХУВЬ НЬ БОНДЫН ЗАХ ЗЭЭЛ ХАМГИЙН ӨНДӨР ӨГӨӨЖТЭЙ БАЙНА ГЭСЭН ХҮЛЭЭЛТТЭЙ БАЙНА.**

### ӨГӨӨЖИЙН ХАРЬЦУУЛАЛТ

/Засгийн газрын бондуудын өгөөжийг бусад хөрөнгө оруулалтын өгөөжтэй харьцуулснаар/

*Эх сурвалж: LSEG data*




2023 оны 12 сарын 13-ны өдрийн байдлаар АНУ-ын 10 жилийн хугацаат засгийн газрын бондын өгөөж 4.21 хувь буюу S&P 500 индексэд багтаж буй компаниудын дундаж ногдол ашгийн өгөөжөөс 3 дахин өндөр өгөөжтэй байна.

Харин 1 жилийн хугацаат бондын өгөөж үл хөдлөх хөрөнгийн түрээсийн жилийн дундаж өгөөжөөс өндөр байна.

## АНУ-ЫН 10 ЖИЛИЙН ХУГАЦААТ БОНДЫН ӨГӨӨЖИЙГ ТҮҮХЭН ҮЗҮҮЛЭЛТТЭЙ ХАРЬЦУУЛСНААР

*Эх сурвалж: Thomson Reuters Eikon*




АНУ-ын 10 жилийн хугацаат бондын өгөөж 2007 оны 6 сарын 12 өдрөөс хойших хамгийн өндөр түвшиндээ хүрлээ.

Ирэх онд АНУ-ын төв банкны бодлогын хүү буурах хүлээлттэй байгаагаас шалтгаалж бондын өгөөж буурч байна.

## БОНДУУДЫН ӨГӨӨЖ ЦААШИД БУУРАХ УУ?

*Эх сурвалж: BofA Global Fund Manager Survey*




Түүхэн үзүүлэлтүүдтэй харьцуулахад бондын өгөөж ирэх онд буурах магадлал өндөр байна.

Гол шалтгаан нь мөнгөний хатуу бодлого ирэх онд буурах хүлээлттэй байгаагаас шалтгаалж хямд үнэтэй байгаа нээлттэй бондуудын үнэ өсөх хүлээлт үүсээд байна.

Жишээлбэл, АНУ-ын 20 жилийн хугацаатай засгийн газрын бондын үнэ 53 ам.доллараар арилжигдаж байна.

Иймд санхүүжилтийн зардал болон бодлогын хүү өндөр байгаа үед бонд болон бонд суурьтай үүсмэл хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд хөрөнгө оруулах нь оновчтой юм.

# BLACKROCK ISHARES 20+ YEAR TREASURY BOND ETF /TLT.NASDAQ/

Дэлхийн хамгийн том сангийн удирдлагын компани болох Blackrock Inc компанийн гаргасан Ishares 20+ Year Treasury Bond ETF /TLT.NYSE/ нь АНУ-ын 20-оос дээш жилийн хугацаатай бондуудаас бүрдсэн ETF юм.
Тус ETF-ийн суурь бүтээгдэхүүн нь хамгийн эрсдэл багатай бүтээгдэхүүнүүдийг багтаасан бөгөөд сар бүр ногдол ашиг тараах байдлаар байршуулжээ.

## ETF-ИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| Ханш | $94.62 | Ногдол ашгийн өгөөж | 3.87 хувь |
|---|---|---|---|
| **Гаргасан нэгж эрх** | 502.8 сая ширхэг | Beta | 0.082 |
| **Зах зээлийн үнэлгээ** | $47.5 тэрбум | YTD% | -4.96% |
| **Арилжааны идэвх** | 36.9 сая ширхэг | YoY% | -11.3% |
| **52 долоо хоногийн ханш** | $82.42-$109.35 | QTD% | 6.69% |

*Тэмдэглэл: 2023 оны 12 сарын 1-ний өдрөөр* *Эх сурвалж: Thomson Reuters Eikon*

## ETF-ИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| Суурь бүтээгдэхүүн | Эзэмшил% |
|---|---|
| **United States of America** (Government) 1.875% 15-FEB-2051 | 8.15% |
| **United States of America** (Government) 15-AUG-2051 | 7.31% |
| **United States of America** (Government) 1.625% 15-NOV-2050 | 6.44% |
| **United States of America** (Government) 1.875% 15-NOV-2051 | 5.51% |
| **United States of America** (Government) 3% 15-FEB-2048 | 4.83% |
| **United States of America** (Government) 2% 15-FEB-2050 | 4.53% |
| **United States of America** (Government) 4.125% 15-AUG-2053 | 4.40% |
| **United States of America** (Government) 3.125% 15-AUG-2044 | 4.32% |
| **United States of America** (Government) 2.5% 15-FEB-2046 | 4.28% |
| **United States of America** (Government) 2.5% 15-MAY-2046 | 4.08% |

*Тэмдэглэл: 2023 оны 12 сарын 1-ний өдрөөр* *Эх сурвалж: Thomson Reuters Eikon*

## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН МЭДЭЭЛЭЛ

| № | Хөрөнгө оруулагчид | Эзэмшил |
|---|---|---|
| 1 | Managed Account Advisors LLC | 7.20% |
| 2 | Morgan Stanley Smith Barney LLC | 5.19% |
| 3 | Envestnet Asset Management | 3.21% |
| 4 | Rafferty Asset Management LLC | 3.11% |
| 5 | Morgan Stanley & Co.LLC | 2.59% |
| 6 | BofA Global Research (US) | 2.50% |
| 7 | Susquehanna International Group LLP | 2.46% |
| 8 | Blackrock Fund Advisors | 1.82% |
| 9 | UBS Financial Services, Inc | 1.71% |
| 10 | Fidelity Management & Research Company LLC | 1.58% |

*Тэмдэглэл: 2023 оны 12 сарын 1-ний өдрөөр* *Эх сурвалж: Thomson Reuters Eikon*

## ТЕХНИК ШИНЖИЛГЭЭ /TLT.NASDAQ/



**А.Билгүүн**
*Техник шинжээч, Хөрөнгө удирдлага, судалгааны газар*







Инфляцыг бууруулах ажлын хүрээнд АНУ-ын төв банк бодлогын хүүг эрчимтэй нэмэгдүүлсний нөлөөгөөр TLT-гийн ханш 2004 оны түвшинд эргэн ирээд байна.

Цаашид, АНУ-ын төв банкны хэрэгжүүлэх мөнгөний бодлого болон 2020 оны 3 сараас хойш үргэлжилсэн уналтын чиг хандлагын бүтцийг задлан үзвэл 180 орчим ам.доллараас эхэлсэн уналт 80 ам.долларт дуусах боломжтой юм.

Одоогоор уналтын трендээс өсөлтийн тренд рүү шилжих завсрын үйл явц явагдаж байна. TLT-гийн хамгийн эхний өсөлтийн бай 109 орчимд байрлаж байна.

# ZOOM VIDEO COMMUNICATIONS INC

/ZM.NASDAQ/

**Холбоо барих:** Голомт Капитал ҮЦК
**Судалгаа бэлтгэсэн:** Хөрөнгө удирдлага. Судалгааны хэлтэс
**Хаяг:** Парк Плэйс оффис, 4 давхар, 403 тоот, Чингисийн өргөн чөлөө-24
**Утас:** (+976) 7012-1530
**Цахим хаяг:** http://golomtcapital.com/
**Email:** info@golomtcapital.com
**Гадаад арилжааны брокер:**
(+976) 8610-3636
(+976) 8006-9977



**Т.Азтүшиг**
*Ахлах шинжээч, Хөрөнгө удирдлага, судалгааны газар*

## КОМПАНИЙН ТУХАЙ

Zoom Video Communications Inc нь технологи дээр суурилсан онлайн видео харилцаа холбооны платформ, програм хангамжийн бүтээгдэхүүн үйлчилгээг хангаан үзүүлдэг.
Zoom компанийн голлох бүтээгдэхүүнүүдээс дурдвал Zoom One, Zoom Meetings, Zoom phone, Zoom team Chat, Zoom mail, Zoom Calendar, Zoom Events, Zoom Sessions, Zoom Webinars, Zoom Contact Center, Zoom AI, Zoom Developer Platform, Zoom App зэрэг бүтээгдэхүүнүүд ордог.
Zoom компанийн тус платформыг засгийн газар, санхүүгийн байгууллагууд, эрүүл мэндийн салбар, аж үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, боловсрол энтертайнмент зэрэг салбарын томоохон байгууллагууд ашигладаг.

Zoom Video Communications Inc компани анх 2011 оны 4 сард Eric Yuan 40 ажилтантайгаар үүсгэн байгуулагдсан бөгөөд 2023 оны 1 сарын байдлаар 8,484 ажилтантай 219,700 байгууллагын харилцагчтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

**Зорилтот ханш**
USD 96.11

**Өмнөх зорилт**
USD 69.86

**Хувьцааны ханш**
USD 69.86

**Боломжит өсөлт**
+37.57%

*Тэмдэглэл:*
*Хаалтын ханш 2023 оны 12 сарын 20 өдрийн байдлаар*

## ЗАХ ЗЭЭЛ ДЭЭР

| | |
|---|---|
| Зах зээлийн үнэлгээ | **$21.79 тэрбум** |
| Дундаж арилжааны идэвх | **19,86 сая ш** |
| Хувьцааны тоо ширхэг | **304.42 сая ш** |
| Нээлттэй арилжаалагдаж буй | **234.75 сая ш** |

## 52 ДОЛОО ХОНОГИЙН ХАНШ



## ХАРЬЦАА, ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| Жил | 2021 | 2022 | 2023 |
|---|---|---|---|
| Нэгж хувьцаанд ногдох ашиг | 3.89 | 2.33 | 0.77 |
| Үнэ-орлогын харьцаа (P/S) | 11.51 | 5.19 | 4.84 |
| Үнэ-ашгийн харьцаа (P/E) | 31.45 | 220.03 | 82.93 |
| Үнэ-дансны үнийн харьцаа (P/B) | 7.98 | 3.55 | 2.93 |
| Ногдол ашгийн өгөөж | N/A | N/A | N/A |
| Хөрөнгийн өгөөж (ROA) | 8.87% | 15.39% | 18.29% |
| Өмчийн өгөөж (ROE) | 31.82% | 63.29% | 70.38% |

## БУСАД ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| | |
|---|---|
| Стандарт хазайлт (5 жил) | 62.21% |
| Beta (5 жил) | -0.09 |
| Дундаж өгөөж (5 жил) | 4.39% |
| WACC | - |
| Sharpe харьцаа | -0.20 |
| Altman Z оноо | 8.60 |
| Ногдол ашгийн өгөөж | - |

Zoom Video Communications Inc компани нь 2019 оны 4 сарын 18 өдөр NASDAQ-ын хөрөнгийн бирж дээр IPO хийсэн.

